



ЗАВСРЫН ҮЕИЙН ХУРААНГУЙ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2018 болон 2019 оны 6-р сарын 30-ны өдрөөр дуусгавар
болсон гурван сар болон хагас жилийн тайлан

*(Канад доллараар)
(Аудитаар баталгаажаагүй)*

Удирдлага бэлтгэв – Уншигчдад хүргүүлэх мэдэгдэлтэй танилцана уу.

УНШИГЧДАД ХҮРГҮҮЛЭХ МЭДЭГДЭЛ

National Instrument 51-102 Мэдээллийн ил тод байдлын үүрэг хариуцлага, 4-р хэсэг, 4.3 (3) а-д заасны дагуу хэрэв завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг аудитор хянан, баталгаажуулаагүй тохиолдолд энэхүү мэдэгдлийг хавсаргах үүрэг хүлээдэг. Энэхүү аудитаар баталгаажуулаагүй завсрын үеийн хураангуй нэгтгэсэн тайланг Компанийн удирдлага бэлтгэсэн. Удирдлага нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорацийн 2018 оны 12 сарын 31 болон 2019 оны 6 сарын 30-ны байдлаар санхүүгийн тайланг нэгтгэн, 2018, 2019 оны 6 сарын 30-аар дуусгавар болсон 3 ба 6 сарын хугацааны нийт алдагдал, эздийн өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний мэдээллийг боловсруулсан. Компанийн хараат бус аудитор нь 2018, 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон завсрын үеийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийх, хянах болон ямарваа нэгэн байдлаар мэдээллийн үнэн зөв байдлыг баталгаажуулаагүй болно. Уншигчдын зорилготой нийцэхгүй байх магадлалтай тул энэхүү мэдэгдлийг хүргүүлэв.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй, нэгтгэсэн завсрын санхүүгийн тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

	Тодруулга	2019.06.30	2018.12.31
Хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		\$ 353,842	\$ 1,748,249
Дансны авлага		157,343	113,412
Урьдчилж төлсөн зардал		92,560	34,633
		603,745	1,896,294
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	6	18,642,296	15,687,348
Үндсэн хөрөнгө		119,180	125,277
		18,761,476	15,812,625
Нийт хөрөнгийн дүн		\$ 19,365,221	\$ 17,708,919
Өр төлбөр ба эздийн өмч			
Арилжаа болон бусад өглөг		\$ 753,436	\$ 224,387
Өр төлбөрийн нийт дүн		\$ 753,436	\$ 224,387
Эздийн өмч			
Хувьцаат өмч	8	\$ 106,504,651	\$ 104,003,644
Нэмж төлөгдсөн капитал		16,576,663	16,110,116
Хуримтлагдсан алдагдал		(1,524,036)	(955,713)
Алдагдал		(102,945,493)	(101,673,515)
Эздийн өмчийн дүн		18,611,785	17,484,532
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн		\$ 19,365,221	\$ 17,708,919

Гэрээгээр хүлээсэн үүрэг (Тодруулга 7)

Тайлант хугацаанд өрнөсөн үйл явдлууд (Тодруулга 13)

Дагалдах тодруулгууд нь хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

Төлөөлөн Удирдах Зөвлөл ("ТУЗ")-ийг төлөөлж баталсан:

Гарын үсэг зурсан "Жон П.Бюрн"

_____ ТУЗ-ийн гишүүн

Гарын үсэг зурсан "Т. Лэйтон Крофт"

_____ ТУЗ-ийн гишүүн

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын алдагдлын дэлгэрэнгүй тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

	6.30-аар дуусгавар болсон гурван сар		6.30-аар дуусгавар болсон зургаан сар		
	Тодруулга	2019	2018	2019	2018
Үйл ажиллагааны зардал					
Хайгуул, үнэлгээний зардал		\$ 246,036	\$ 673,015	\$ 423,586	\$ 899,602
Ерөнхий ба удирдлагын зардал	9	497,928	791,439	844,244	1,278,047
Үйл ажиллагаанаас учирсан алдагдал		743,964	1,464,454	1,267,830	2,177,649
Санхүүгийн орлого		(7,425)	(9,404)	(17,657)	(21,214)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз (олз)		18,752	(15,579)	21,805	(15,301)
Цэвэр алдагдал		\$ 755,291	\$ 1,439,471	\$ 1,271,978	\$ 2,141,134
Бусад дэлгэрэнгүй алдагдал:					
Охин компанийн хөрвүүлгээс үүдсэн гадаад валютын ханшийн зөрүү		378,326	79,379	568,323	(305,070)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		378,326	79,379	568,323	(305,070)
Нийт алдагдал		\$ 1,133,617	\$ 1,518,850	\$ 1,840,301	\$ 1,836,064
Нэгж хувьцаанд ногдох суурь алдагдал		\$ 0.01	\$ 0.01	\$ 0.01	\$ 0.01
Нийт хувьцааны жигнэсэн дундаж тоо		174,204,930	149,901,990	170,472,971	147,008,699

Дагалдах тодруулгууд нь хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын өмчийн өөрчлөлтийн тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

	Тодруулга	Хувьцааны тоо ширхэг	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Хуримтлагдсан бусад дэлгэрэнгүй алдагдал	Алдагдал	Нийт эздийн өмч
2018.01.01-ний үлдэгдэл		145,963,086	\$ 99,890,270	\$ 13,775,386	\$ (894,855)	\$ (98,016,525)	\$ 14,754,276
Тайлант хугацааны нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(2,141,134)	(2,141,134)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	305,070	-	305,070
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр зардал		14,834,580	3,650,261	1,357,750			5,008,011
Хэрэгжүүлсэн опцион		978,125	274,950	(100,700)			174,250
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		-	-	892,014			892,014
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		15,812,705	3,925,211	2,149,064	-	-	6,074,275
2018.06.30-ний үлдэгдэл		161,775,791	\$ 103,815,481	\$ 15,924,450	\$ (589,785)	\$ (100,157,659)	\$ 18,992,487
2019.01.01-ний үлдэгдэл		162,426,416	\$ 104,003,644	\$ 16,110,116	\$ (955,713)	\$ (101,673,515)	\$ 17,484,532
Тайлант хугацааны нийт алдагдал							
Цэвэр алдагдал		-	-	-	-	(1,271,978)	(1,271,978)
Бусад дэлгэрэнгүй алдагдал		-	-	-	(568,323)	-	(568,323)
Хаалттай хүрээнд гаргасан хувьцааны цэвэр за	8	11,014,544	2,194,102	225,692			2,419,794
Хэрэгжүүлсэн опцион	8	1,105,000	276,900	(107,100)			169,800
ИОХЭ	8	175,069	30,005	(30,005)			-
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	8	-	-	377,960			377,960
Эзэмшигчидтэй хийсэн нийт хэлцэл гүйлгээ		12,294,613	2,501,007	466,547	-	-	2,967,554
2019.03.31-ний үлдэгдэл		174,721,029	\$ 106,504,651	\$ 16,576,663	\$ (1,524,036)	\$ (102,945,493)	\$ 18,611,785

Дагалдах тодруулгууд нь хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын мөнгөн гүйлгээний тайлан

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулагдсан)

	Тодруулга	06.30-аар дуусгавар болсон гурван сар		06.30-аар дуусгавар болсон зургаан сар	
		2019	2018	2019	2018
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Цэвэр алдагдал		\$ (755,291)	\$ (1,439,471)	\$ (1,271,978)	\$ (2,141,134)
Мөнгөн бус гүйлгээнүүд:					
Элэгдэл, хорогдол		5,764	5,382	11,277	10,424
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр		325,509	776,668	377,960	892,014
Санхүүгийн орлого		(7,425)	(9,404)	(17,657)	(21,214)
Гадаад валютын ханшийн зөрүүний гарз (олз)		18,752	(15,579)	21,805	(15,301)
Мөнгөн бус эргэлтийн хөрөнгийн өөрчлөлт		359,843	267,059	435,182	261,428
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(52,848)	(415,345)	(443,411)	(1,013,783)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Энгийн хувьцаа гаргасан цэвэр зардал	8	-	5,008,011	2,419,794	5,008,011
Опцион хэрэгжүүлсэн төлбөр	8	124,300	64,875	169,800	174,250
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		124,300	5,072,886	2,589,594	5,182,261
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ					
Хайгуул, хөрөнгийн үнэлгээний зардал		(1,561,424)	(1,789,160)	(2,324,957)	(2,280,479)
БЦАТ буцаан худалдан авалт	7	(1,200,000)		(1,200,000)	
Үндсэн хөрөнгийн зардал		(3,323)	(1,447)	(9,593)	(9,748)
Хүүний орлого		7,425	9,404	17,657	21,214
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		(2,757,322)	(1,781,203)	(3,516,893)	(2,269,013)
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(20,605)	18,737	(23,697)	22,092
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн өсөлт (бууралт)		(2,706,475)	2,895,075	(1,394,407)	1,921,557
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эхэнд		3,060,317	2,251,684	1,748,249	3,225,202
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө, хугацааны эцэст		\$ 353,842	\$ 5,146,759	\$ 353,842	\$ 5,146,759

Дагалдах тодруулгууд нь хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайлангийн салшгүй нэг хэсэг юм.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

1. Үйл ажиллагааны тухай:

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” “Корпораци” эсвэл “Компани” гэх) нь Канад улсад төвтэй, үнэт болон суурь металлын хайгуулын үйл ажиллагааг Монгол улсад эрхэлдэг компани юм. Компанийн үнэт цаас нь Торонтогийн Хөрөнгийн Бирж дээр “ERD”, Монголын Хөрөнгийн Бирж дээр “ERDN” тикертэйгээр арилжаалагддаг. Компанийн албан хаяг нь 1300-1969 Upper Water Street, Halifax, Nova Scotia, B3J 2V1.

Ашигт малтмалын геологийн баялаг нь эрдсийн нөөц биш бөгөөд эдийн засгийн хувьд олборлох боломжтой эсэх нь бүрэн баталгаажуулсан болно. Компанийн үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх, одоогийн эрдсийн нөөцийг эдийн засгийн хувьд үр ашигтайгаар олборлох эсэх нь Компанийн санхүүжилт амжилттай татан төвлөрүүлэх, төслүүдийг үргэлжлүүлэн хөгжүүлэхээс хамаарна.

2. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчим:

Энэхүү аудитаар баталгаажуулсан санхүүгийн нэгтгэсэн тайланг ирээдүйд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх, бизнесийн хэвийн үйл ажиллагааны туршид хөрөнгийн өгөөжийг хүртэх, өр төлбөр, төлбөрийн үүргээ үйл ажиллагааны хүрээнд биелүүлэх боломжтой гэх тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчимд тулгуурлан боловсруулав. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчим хэр зохистойг үнэлэхийн тулд гүйцэтгэх удирдлагын зүгээс тайлант хугацааны төгсгөлөөс хойш ирээдүйн 12 сарын хугацааны мэдээллийг харгалзан үзсэн. Гүйцэтгэх удирдлага нь дүгнэлт гаргахдаа үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэхэд Компанийн чадварт эргэлзээ төрүүлж болзошгүй үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдлуудыг тооцоолсон болно. Эдгээрийг доор тайлбарлав.

Компани нь 2017, 2018 оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болсон тайлант жил, 2019 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон хагас жилд алдагдал хүлээж, мөнгөн гүйлгээ хасах утгатай гарсан бөгөөд 2019 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон хагас жилд \$102,190,202 хуримтлагдсан алдагдалтай гарсан. Эргэлтийн хөрөнгө 2019 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон хагас жилд \$149,691 байсан нь 2018 оны 12 дугаар сарын 31-ны \$1,671,907 байдалтай харьцуулахад \$1,821,598-аар буурсан үзүүлэлт юм. 2019 оны 7 сарын 9-нд эцэслэсэн хаалттай хүрээнд хийгдсэн \$2,001,500 кан.долларын санхүүжилтээр (Тодруулга 13-аас танилцана уу) өнөөгийн эргэлтийн хөрөнгө нь 2019 оны 9 сар хүртэл төлөвлөсөн зардлуудыг санхүүжүүлэхэд хангалттай гэж компанийн удирдлага үзэж байна. Компанийн хөрөнгөө борлуулах, өр төлбөрөө барагдуулах буюу хайгуулын хөтөлбөрүүдээ өргөжүүлэх чадвар нь хөрөнгийн санхүүжилтээ баталгаажуулах, хамтын хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулах буюу хөрөнгөө бэлэн мөнгөнд хөрвүүлэх зэрэг нь тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмыг хангаж, үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхэд нөлөөтэй гэж гүйцэтгэх удирдлага тооцоолсон болно. Нэмэлт санхүүжилт шаардлагатай эсэх, хугацаа төлөвлөлт зэрэг нь Компанийн хайгуулын тасралтгүй үргэлжлэх хөтөлбөрүүдийн үр дүн болон зах зээлийн нөхцөл байдлаар тодорхойлогдоно. Компани нь ирээдүйд шаардлагатай болж болзошгүй хөрөнгийг татан төвлөрүүлэх чадвартай эсэхийг тооцоолох боломжгүй.

Хэрэв тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмын төсөөлөл бодитой бус байсан бол хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланд шаардлагатай тохируулалтыг тусгаагүй. Тасралтгүй үйл ажиллагаа эрхлэх зарчмын суурь нь бодитой бус байх тохиолдолд хөрөнгийн дансны үнэ, тайлагнасан орлого, зардал, санхүүгийн байдлын тайлангийн ангилалд тохируулалт хийх шаардлагатай болно.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулахгүй)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

3. Тайлангийн үндэслэл

2019 оны 6 дугаар сарын 30-нд дуусгавар болсон хагас жилийн хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг (“Завсрын үеийн санхүүгийн тайлан”) Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (“НББОУС”) 34 – завсрын санхүүгийн тайлагналын дагуу боловсруулсан. Завсрын үеийн санхүүгийн тайлан нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)-ийн гаргасан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулагдсан 2018 оны 12 дугаар сарын 31-нд дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан (“Жилийн эцсийн санхүүгийн тайлан”) -тай хамтад нь танилцах шаардлагатай.

Хураангуй нэгтгэсэн санхүүгийн тайланг тайлагнахыг 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдөр ТУЗ-өөр зөвшөөрсөн болно.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөгдсөн стандартууд болон тайлбарууд

Эрдэнэ Ресурс нь 2019 оны 1 дүгээр сарын 1-нээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарын дагуу тайлагнан, мөрдөж эхэлсэн. Энэхүү өөрчлөлтүүд нь холбогдох шилжилтийн нөхцөлүүдийн дагуу мөрдөгдөж байна.

СТОУС 16 - Түрээс

Компани нь 2019 оны 1 сарын 1-ээс СТОУС 16 Түрээсийн стандартыг буцан үйлчлэх нөхцөлтэйгөөр мөрдөж эхэлсэн. 2018 оны мэдээлэл нь энэхүү тайланд тусгагдаагүй бөгөөд урьд нь НББОУС 17-д болон холбогдох тайлбаруудад тусгагдсан.

СТОУС 16 нь түрээсийг хэрхэн нягтлах, хэмжих, танилцуулах, мэдээлэхийг тодорхойлдог. Уг стандарт нь нягтлан бодох бүртгэлийн нэг түрээслэгчийн загварыг танилцуулсан ба үндсэн хөрөнгө нь бага өртөгтэй биш бол 12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг түрээслэгчид тавьдаг. НББОУС 17-той адил, энэхүү стандартын дагуу түрээслүүлэгч нь түрээсийн зардлыг үйл ажиллагаа эсвэл санхүүгийн бүрэлдэхүүнээр ангилна.

Компани нь 12 сараас доош хугацааны түрээсийн гэрээ хэлцэл байхгүй тул энэ нь Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэхгүй.

5. Улирлын шинж чанар

Монгол улс дахь цаг агаарын нөхцөл байдлаас шалтгаалан хайгуулын зардал, хайгуул үнэлгээний хөрөнгийн хөрөнгө оруулалтууд нь жилийн хоёр ба гуравдугаар улиралд төвлөрдөг тул компанийн үйл ажиллагаа нь улирлын шинж чанарыг агуулдаг.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө

	Хөндий Алтны Төсөл	Зуун Мод Моли/Зэс	Улаан ба Бусад	Нийт
2018.01.01 үлдэгдэл	\$ 9,700,832	\$ 765,795	\$ 928,216	\$ 11,394,843
Нэмэгдэл	4,291,555	70,074	1,388	4,363,017
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(62,077)	(4,143)	(4,292)	(70,512)
2018.12.31 үлдэгдэл	\$ 13,930,310	\$ 831,726	\$ 925,312	\$ 15,687,348
2019.01.01 үлдэгдэл	\$ 13,930,310	\$ 831,726	\$ 925,312	\$ 15,687,348
Нэмэгдэл	2,255,964	67,091	1,902	2,324,957
БЦАТ буцаан худалдан авалт (Тодруулга 7)	1,200,000			1,200,000
Валютын ханшийн шилжилтийн нөлөө	(503,797)	(39,267)	(26,945)	(570,009)
2019.06.30 үлдэгдэл	\$ 16,882,477	\$ 859,550	\$ 900,269	\$ 18,642,296

Компанийн Монгол улс дахь ашигт малтмалын хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийг Компанийн охин компаниуд болох Эрдэнэ Монгол ХХК, Аниан Ресорзис ХХК, Лидер Эксплорэйшн ХХК эзэмшдэг. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл нь гурван жилийн хугацаанд хүчинтэй байх ба хугацааг 12 хүртэл жилээр сунгах боломжтой. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаатай олгодог бөгөөд 20 хүртэл жилээр 2 удаа сунгах боломжтой. Тусгай зөвшөөрлүүдийн жилийн төлбөрийг төлснөөр тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр байна.

Хөндий Алтны Төсөл

Хөндий Алтны Төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт, Баян Хөндийн нөөцийг агуулсан 2,309 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, 2,205 га Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг хамарч оршдог. 4,669 га Цэнхэр Номин тусгай зөвшөөрлийн талбайд Алтан Нар алт, мөнгө, хар тугалга, цайрын хайгуулын төсөл оршдог. 2018 оны 12 сарын 31-ээс өмнө Цэнхэр Номин, Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн хайгуул болон үнэлгээг тусдаа тайлагнаж байсан. 2018 оны сүүлээр энэхүү тусгай зөвшөөрлүүдийг хамтад нь хөгжүүлж, хайгуул, үнэлгээний хөрөнгө, зардлуудыг хамтад нь тайлагнах болсон.

2019 оны 8 сарын 5-нд Монгол улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (“АМГТГ”)-аас Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий нөөцөд ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон бөгөөд үүнд хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай хамаарахгүй.

Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрөл нь “Монгол улсын баруун өмнө зүгт Баянхонгор аймаг дахь Баян Хөндий Алтны Төсөл” (“Bayan Khundii Gold Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia”) нэртэйгээр бүртгүүлсэн NI 43-101 эрдсийн нөөцийн техникийн тайланг багтаасан 2,309 га талбайг хамарна. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Эрдэнэ Ресурсийн Алтан Сум (“Altan Arrow”), Хойд Хөндий (“Khundii North”) болон Баруун Хөндий (“Khundii West”) хэтийн төлөв бүхий талбайнууд багтаж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай олгогдсон бөгөөд компани үргэлжлүүлэн 70 жил хүртэл сунгах боломжтой.

Баян Хөндийн хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой 2,205 га бүхий талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрөлд хамаарахгүй болно. Хөндий хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 10 дахь жилдээ хүчинтэй байгаа бөгөөд 12 жилийн хугацаа дуусахаас өмнө Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулж)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

6. Хайгуул, үнэлгээний хөрөнгө (үргэлжлэл)

Компани нь 2016 оны 7 сарын 1-ээс капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Үүнээс өмнө зөвхөн Хөндий тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

Цэнхэр Номин хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 10 дахь жилдээ хүчинтэй байгаа бөгөөд 12 жилийн хугацаа дуусахаас өмнө Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой. 2015 оны 1 сарын 1-нд Алтан Нарын анхан шатны нөөцийн тооцооллыг гүйцэтгэсэн бөгөөд Компани нь капиталын бодлогын дагуу хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. Компани нь 2015 оноос өмнө зөвхөн Алтан Нартай холбоотой тусгай зөвшөөрлийн төлбөрийг капиталжуулж байсан.

Зуун Мод/ Хөвийн Хар

Зуун Мод төсөл нь Монгол улсын Баянхонгор аймагт байрладаг. 6,041 га талбайг хамардаг. Энэхүү тусгай зөвшөөрлийн талбайд молибден-зэсийн нөөц бүхий орд оршдог. Ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 онд авсан бөгөөд энэхүү тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаанд хүчинтэй, цаашид 20 жилийн хугацаатайгаар 2 удаа сунгах боломжтой.

Улаан ба бусад

Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайтай хил залгаа, нийт 1,780 га талбайг хамардаг. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 4 дэх жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу цаашид 12 жилийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой. 2017 оны 8 сарын 30-нд Эрдэнэ Ресурс нь тусгай зөвшөөрөл эзэмшигч Монгол улсын хуулийн этгээд болох Лидер Эксплорэйшн ХХК-ийн 51%-ийг худалдаж авсан. Эрдэнэ Ресурс нь СТОУС 3-ийн дагуу үнэлгээ гаргасан бөгөөд үнэлгээгээр энэхүү гэрээ хэлцэл нь хөрөнгө худалдан авах ангилалд багтана (бизнес худалдан авах бус) гэсэн дүгнэлтэнд хүрсэн.

Эрдэнэ Ресурс нь 2020 оны 8 дугаар сарын 30 хүртэл \$600,000 ам.долларын хайгуулын ажил гүйцэтгэснээр Лидер Эксплорэйшн ХХК-ийн үлдсэн 49%-ийг зах зээлийн үнэлгээгээр худалдан авах эрх үүснэ. Мөн жилд багадаа \$100,000 ам.долларын хайгуулын ажлыг гүйцэтгэснээр 49%-ийг худалдан авах хугацааг сунгах эрхтэй болно.

2013 оны 4 сард Монгол улсын баруун өмнөд хэсгийн Транс-Алтайн бүс нутагт Компанийн хайгуулын ажлыг санхүүжүүлэх, хамтран ажиллах зорилгоор Тек Ресорсиз Лимитед компанитай хамтран ажиллах гэрээ байгуулсан. Хамтын ажиллагааны хүрээнд 2015 оны эхээр 1,552 га талбайг хамарсан хоёр тусгай зөвшөөрлийн талбайг санхүүжүүлсэн. Одоогоор эдгээр тусгай зөвшөөрлийн талбайд өргөн хүрээгээр хайгуулын ажил хийгдээгүй байна.

7. Гэрээгээр хүлээсэн үүрэг

Үйл ажиллагаатай холбоотой гэрээгээр хүлээсэн үүрэг, түрээс:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

7. Гэрээгээр хүлээсэн үүрэг (үргэлжлэл)

	6 дугаар сарын 30 2019	12 дугаар сарын 31 2018
1 жилээс богино	59,311	41,957
1-ээс 5 жилийн хооронд	-	-
Нийт	\$ 59,311	\$ 41,957

Компанийн Канад болон Монгол дахь оффисын байр болон ажилтнуудын оршин суух байрын түрээсийн хугацаа дараагийн 12 сарын хугацаанд дуусгавар болно.

Эрдэнэ Ресурс нь \$600,000 ам.долларын хайгуулын ажил гүйцэтгэснээр Лидер Эксплорэйшн ХХК-ийн (Улаан) үлдсэн 49%-ийг зах зээлийн үнээр худалдан авах эрх үүснэ. Мөн жилд багадаа \$100,000 ам.долларын хайгуулын ажлыг гүйцэтгэснээр 49%-ийг худалдан авах хугацааг 3 жилээр сунгах эрхтэй. (Тодруулга 6-аас харна уу.)

2016 оны 4 сарын 21-нд Компани нь Цэнхэр Номин ба Хөндий тусгай зөвшөөрлийн хүрээнд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр ("NSR")-ийг Сэндстормд төлөх үүрэг хүлээсэн. 2019 оны 4 сарын 12-нд NSR-ын 50%-ийг \$1.2 сая доллараар худалдан авч, 1% болгон бууруулсан.

8. Хувьцаат капитал

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Гаргасан хувьцаа

2019 оны 2 сарын 28-нд Компани нь хаалттай хүрээнд нийт \$2,533,345 кан.долларыг татан төвлөрүүлсэн. Энэхүү санхүүжилтийн хүрээнд нэгж бүр нь \$0.23 кан.доллараар үнэлэгдсэн нийт 11,014,544 үнэт цаасны нэгжийг гаргасан. Үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг энгийн хувьцаа болон дагалдах нэг варрантаас бүрдэнэ. Энэхүү варрантаар Компанийн энгийн хувьцааг эхний 12 сарын хугацаанд \$0.40 кан.доллар, дараагийн 12 сарын хугацаанд \$0.50 кан.доллараар худалдан авах эрх олгоно. Компани нь санхүүжилттэй холбоотойгоор зуучлалын үйлчилгээний төлбөрт \$62,116 болон 270,070 варрантыг олгосон. Зуучлалын варрантыг үнэт цаасны нэгжийг дагалдах варранттай ижил нөхцөлөөр хэрэгжүүлэх боломжтой. Мөн компани нь хаалттай хөрөнгө татан төвлөрүүлэлтийн хүрээнд \$51,435-ын зардал гаргасан нь нийт татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээг \$2,419,794 болгосон.

Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр

2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компани нь \$377,960 (2018 – \$892,014) кан.долларын хувьцаанд суурилсан нөхөн төлбөрийг нэгтгэсэн алдагдалд зарлагдсан, үүнээс \$93,777 (2018 – \$355,037) кан.долларыг хайгуулын зардалд тооцсон.

Хувьцааы опцион

Опционыг Компанийн опционы хөтөлбөрийн дагуу олгосон өдрөөс эхлэн таван жилийн хугацаанд хэрэгжүүлж болдог. Опционыг хэрэгжүүлэгчийн опцион хэрэгжүүлэх төлбөр нь хувьцаат капиталд тооцогдоно. 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сарын хугацаанд Компани нь хэрэгжүүлэх боломжтой 1,105,000 хувьцааны опцион гаргасан бөгөөд \$169,800 орлого олсон.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

8. Хувьцаат капитал (үргэлжлэл)

2019 оны 2-р улиралд жигнэсэн дундаж хэрэгжүүлэх үнэ нь \$0.20 кан.долларын үнэ бүхий 2,520,000 опционыг ТУЗ-ийн гишүүд, ажилтан албан тушаалтнуудад олгосон. Опцион тус бүрийн үнэ цэнийг опцион гаргах үед Блэк Шолсийн опционы үнэлгээний загварыг ашиглан тооцсон бөгөөд хувьцаанд суурилсан нөхөн төлбөр ба захиргааны зардалд \$227,500 кан.доллараар зардал болж тусгагдсан (2018 – \$804,600). 2019 оны 6 сарын 18-нд 230,000 опционы хэрэгжүүлэх хугацаа дууссан.

2019 оны 6 сарын 30-ны байдлаар хэрэгжүүлэх боломжтой опционы мэдээллийг доор харуулав.

	Опционы тоо		Хэрэгжүүлэх боломжтой жигнэсэн дундаж үнэ
2019.01.01 байдлаар	11,335,000	\$	0.43
Олгосон	2,520,000		0.20
Хугацаа дууссан	(230,000)		0.16
Хэрэгжүүлсэн	(1,105,000)		0.15
2019.06.30 байдлаар	12,520,000	\$	0.42

2019 оны 6 сарын 30-ны байдлаар хэрэгжүүлэх боломжтой опционы хугацааг харуулав.

Үнэ	Хэрэгжүүлэх боломжтой опционы тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)		Хэрэгжүүлэх боломжтой опционы жигнэсэн дундаж үнэ
\$0.15 - \$0.24	4,690,000	3.32	\$	0.18
\$0.25 - \$0.49	5,010,000	3.19		0.38
\$0.50 - \$0.87	2,820,000	2.78		0.86
	12,520,000	3.15	\$	0.42

Варрант

2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сарын хугацаанд буюу 2019 оны 2 сарын 28-нд хаалттай хүрээнд Компани нь нийт 11,014,544, зуучлалын үйлчилгээний төлбөрийн 270,070 варрант гаргасан. Варрантын нөхцөл нь санхүүжилт хаагдсанаас хойш хоёр жилийн турш эхний 12 сарын хугацаанд компанийн энгийн хувьцааг \$0.40, дараагийн 12 сарын хугацаанд \$0.50 кан.доллараар худалдан авах эрхтэй.

Доорх хүснэгтэд 2019 оны 6 сарын 30-ны байдлаар варрантын мэдээллийг үзүүлэв:

	Варрантын тоо		Жигнэсэн дундаж хэрэгжих үнэ
2019.01.01 байдлаар	12,389,904	\$	0.65
Гаргасан	11,284,614		0.40 - 0.50
Хугацаа дууссан	(1,075,324)		1.20
2019.06.30 байдлаар	22,599,194	\$	0.53

2019 оны 6 сарын 30-ны байдлаар гэрээний хугацаа дуусаагүй варрантууд:

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулсан)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

8. Хувьцаат капитал (үргэлжлэл)

Хэрэгжүүлэх боломжтой үнэ	Хэрэгжүүлэх боломжтой варрантын тоо	Гэрээний жигнэсэн дундаж хугацаа (үлдсэн жил)
\$0.40 - \$0.50	11,284,614	1.69
\$0.51 - \$0.60	11,314,580	1.92
	22,599,194	1.81

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх (ИОХЭ)

Ирээдүйд олгогдох хувьцааны эрх нь Компанийн төлөвлөгөөний дагуу ТУЗ, ажилтан албан тушаалтнуудын урамшууллын хөтөлбөр бөгөөд хугацаагүй, үйлчилгээний хугацаа дуусгавар болсноор худалдан авах боломжтой. 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сарын хугацаанд Компани нэгж тус бүрийг \$0.20 кан.доллараар үнэлсэн 762,391 ширхэг ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон. (2018 – \$0.40 кан.доллараар үнэлсэн 212,564 ширхэг ирээдүйд олгогдох хувьцааны эрх олгосон) Бодит үнэлгээ нь \$150,460 кан.доллар (2018 - \$84,914) бүхий ирээдүйд олгогдох хувьцааны эрх нь Захиргаа, удирдлагын зардал болон хайгуулын зардалд тусгагдсан.

2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сарын хугацаанд Эрдэнэ Ресурс нь ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн хөтөлбөрийн дагуу нэгж бүр нь \$0.17 кан.доллараар үнэлсэн 175,069 хувьцааг гаргасан. (2018 - nil)

2019 оны 6 сарын 30-ны байдлаар ирээдүйд олгогдох хувьцааны эрхийн мэдээлэл:

	Тоо ширхэг	Жигнэсэн дундаж олгогдох үнэ
2019.01.01 байдлаар	3,954,118	\$ 0.19
Олгосон	762,391	0.20
Гаргасан	(175,069)	0.17
2019.06.30 байдлаар	4,541,440	\$ 0.19

9. Хайгуул болон үнэлгээний зардал

2018 болон 2019 оны 6 сарын 30-ны байдлаар гурав болон зургаан сарын хугацааны хайгуул болон үнэлгээний зардлын мэдээллийг дор харуулав:

	6.30-нд дуусгавар болсон 3 сар		6.30 дуусгавар болсон 6 сар	
	2019	2018	2019	2018
Элэгдэл хорогдол	3,623	3,814	7,229	7,362
Шууд зардал	120,744	235,281	227,802	370,324
Ажилтан, албан тушаалтнуудын нөхөн олговор	32,269	88,075	94,778	166,879
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	89,400	345,845	93,777	355,037
	246,036	673,015	\$ 423,586	\$ 899,602

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

10. Захиргаа, удирдлагын зардал

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурав болон зургаан сарын захиргаа, удирдлагын зардлын мэдээллийг доор харуулав:

	6 сарын 30-нд дуусгавар болсон 3 сар		6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сар	
	2019	2018	2019	2018
Захиргааны үйлчилгээ	\$ 94,207	\$ 149,359	\$ 204,123	\$ 270,652
Элэгдэл, хорогдол	2,153	1,554	4,065	3,053
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр, нөхөн	37,091	51,107	65,009	75,142
Хөрөнгө оруулагчтай харилцах,	23,093	24,978	55,316	90,149
Оффис, бусад	30,205	34,783	62,123	64,166
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	46,087	55,676	77,886	117,978
Зохицуулагч байгууллагын төлбөр, зардлууд	22,568	26,481	70,805	86,803
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	236,109	430,823	284,183	536,977
Томилолтын зардал	6,415	16,678	20,734	33,127
	\$ 497,928	\$ 791,439	\$ 844,244	\$ 1,278,047

11. Санхүүгийн хэрэгслүүд

Зээлийн эрсдэл:

Зээлийн эрсдэл нь санхүүгийн хөрөнгийн хамгийн өндөр эрсдлийг агуулдаг. Тайлагнах өдрөөр тасалбар болгон зээлийн эрсдэл нь хамгийн их өндөр байгаа нь:

	Бүртгэгдсэн дүн	
	6.30 2019	12.31 2018
Бэлэн мөнгө, түүнтэй адилтгах	\$ 353,842	\$ 1,748,249
Авлага	157,343	113,412
	\$ 511,185	\$ 1,861,661

Компани нь бэлэн мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канад улсын тэргүүлэгч санхүүгийн байгууллагуудад байршуулж, зээлийн эрсдэлийг удирддаг. 2019 оны 6 сарын 30-нд бэлэн мөнгөний үлдэгдлийн 39% буюу \$136,519 кан.долларыг Канад улсаас гадуурх банкуудад байршуулсан. (2018.12.31 – \$66,342 буюу 4%)

Төлбөрийн чадварын эрсдэл:

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлдэг. Компани нь энэхүү эрсдэлийг удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг.

Компани нь 2019 онд төлөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд ажлын капитал хүрэлцэхгүй бөгөөд дахин санхүүжилт татан төвлөрүүлэх шаардлагатай. (Тодруулга 2-оос танилцана уу.)

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

11. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

Зах зээлийн эрсдэл:

Зах зээлийн эрсдэл гэж үнэт цаасны ханш, таваарын зах зээл, валютын ханш, хүүгийн түвшин зэрэг зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалан өөрчлөгдөх магадлалтай эрсдэлүүдийг хэлнэ.

а) Хүүгийн эрсдэл

2019 оны 6 сарын 30-ны байдлаар Компани нь хүү тооцогдох өр төлбөргүй бөгөөд хүүгийн хувь хэмжээтэй холбоотой аливаа эрсдэлд өртөхгүй болно.

б) Гадаад валютын эрсдэл

Компани нь Монгол улсад үйл ажиллагаа эрхэлдэг тул гадаад валютын эрсдэлд өртөх магадлалтай. Энэхүү эрсдэлийг бууруулахын тулд Компани нь бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын нэр хүндтэй санхүүгийн байгууллагуудад байршуулдаг. Компани нь гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалан хязгаар тогтоох санхүүгийн хэлцлүүдийг ашигладаггүй бөгөөд төсвийн хэмжээнд нийцүүлэн ханш боломжийн байх үед гадаад валютыг урьдчилан худалдаж авдаг.

Компанийн гадаад валют (ам.доллар)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав.

	6.30 2019	12.31 2018
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 172,040	\$ 96,157
Худалдаа, бусад авлага	-	-
Худалдаа, бусад төлөгдөх	(35,884)	(24,244)
	\$ 136,156	\$ 71,913

Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$13,600 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай. (2018 оны 12 сарын 31 - \$7,200)

Компанийн гадаад валют (төгрөг)-ын эрсдэлд өртөх байдлыг доор харуулав.

	6.30 2019	12.31 2018
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 10,024	\$ 3,432
Худалдаа, бусад авлага	3,890	7,218
Худалдаа, бусад төлөгдөх	(178,258)	(22,159)
	\$ (164,344)	\$ (11,509)

Монгол төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$16,400 долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай. (2018 оны 12 сарын 31 – \$1,200)

с) Үнийн эрсдэл

Компанийн санхүүгийн хэрэгслүүд нь эрдсийн хайгуул, олборлолтын салбарын таваарын үнийн хэлбэлзлээс бусад байдлаар үнийн шууд эрсдэлд орох магадлал багатай.

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажуулаагүй)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

11. Санхүүгийн хэрэгслүүд (үргэлжлэл)

Бодит үнэ цэн:

Санхүүгийн нэгтгэсэн тайланд бодит үнэ цэнээр бүртгэсэн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийн шатлалыг санхүүгийн тайлангийн тодруулгад дараах байдлаар тусгасан. Үүнд:

	2019.06.30			2018.12.31		
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Бодит үнэ цэнээр хэмжигдсэн хөрөнгө:						
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 353,842	\$ -	\$ -	\$ 1,748,249	\$ -	\$ -
Авлага	-	157,343	-	-	113,412	-

12. Холбогдох талууд

Компанийн голлох удирдлагын ажилтнуудад ТУЗ-ийн гишүүд, ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал, санхүү хариуцсан захирал ба дэд ерөнхийлөгч, хайгуул хариуцсан дэд ерөнхийлөгч, үйл ажиллагаа хариуцсан дэд ерөнхийлөгч, зөвшөөрөл стратеги хариуцсан дэд ерөнхийлөгч нар багтана. Голлох удирдлагын ажилтнуудын цалин урамшууллыг дор харуулав.

	6 сарын 30-нд дуусгавар болсон зургаан сар	
	2019	2018
Богино хугацааны цалин урамшуулал	\$ 444,124	\$ 568,502
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	290,946	767,971
	\$ 735,070	\$ 1,336,473

13. Тайлант хугацаанд өрнөсөн үйл явдлууд

2019 оны 7 сарын 9-нд Компани нь нэгж тус бүрийг \$0.20 үнэлсэн 10,007,500 ширхэг үнэт цаасны нэгжийг гарган, \$2,001,500 кан.долларыг татан төвлөрүүлэхээр танилцуулсан. Үнэт цаасны нэгж бүр нь Компанийн нэг энгийн хувьцаа болон энгийн хувьцаа худалдан авах эрх болох хагас (1/2) варрантаас бүрдэнэ. Варрант бүр нь санхүүжилт хаагдсанаас хойш 2 жилийн дотор нэг энгийн хувьцааг \$0.30 кан.доллараар худалдан авах эрхийг олгоно. Энэхүү хаалттай хүрээнд үйлчилгээний төлбөрт \$35,760 кан.доллар болон 108,800 варрантыг гаргасан. Энэхүү варрантыг хаалттай санхүүжилтийн хүрээнд гаргасан варранттай адил нөхцлөөр хэрэгжүүлнэ.

2019 оны 8 сарын 5-нд Монгол улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (“АМГТГ”)-аас Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий нөөцөд MV-021444 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон.

Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 2018 оны 11 сарын 1-нд RPMGlobal Asia Limited-ийн боловсруулж, “Монгол улсын баруун өмнө зүгт Баянхонгор аймаг дахь Баян Хөндий Алтны Төсөл” (“Bayan Khundii Gold Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia”) нэртэйгээр бүртгүүлсэн NI 43-101 эрдсийн нөөцийн техникийн тайланг багтаасан 2,309 га талбайг хамарна. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Эрдэнэ Ресурсийн Алтан Сум (“Altan Arrow”), Хойд Хөндий (“Khundii North”) болон Баруун Хөндий (“Khundii West”) хэтийн төлөв бүхий талбайнууд багтаж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай олгогдох бөгөөд компани үргэлжлүүлэн 70 жил хүртэл сунгах боломжтой. Баян Хөндийн хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлэх

ЭРДЭНЭ РЕСУРС ДЕВЕЛОПМЕНТ КОРПОРАЦИ

Хураангуй нэгтгэсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн тодруулга

(Канад доллараар)

(Аудитаар баталгаажаагүй)

2018 болон 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

боломжтой 2,205 га бүхий талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрөлд хамаарахгүй болно.

Орчуулга: Энэхүү тайлан нь Англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.



УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ

2018, 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар болон хагас жилийн тайлан

УДИРДЛАГЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА ДҮН ШИНЖИЛГЭЭ
2019 оны 6 сарын 30-ний өдрөөр дуусгавар болсон гурван сар ба хагас жил

Агуулга

	Хуудасны дугаар
Компанийн танилцуулга	3
Онцлох үйл явдлууд	3
Стратеги, хэтийн төлөв	5
Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд	6
Монгол улсын баруун өмнөд бүсэд орших Эрдэнэ Ресурсийн Хөндий Алтны Дүүрэг	6
Хөндий Алтны Төсөл	7
Дүүргийн хэмжээний хайгуул	11
Худалдан авалт	13
Үйл ажиллагааны хэлэлцүүлэг	13
Улирлын үр дүнгийн хураангуй	17
Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц	17
Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл	17
Гэрээгээр хүлээсэн үүрэг	18
Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг	18
Балансын гадуурх зохицуулалт	18
Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол	19
Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт	20
Санхүүгийн хэрэгсэл ба бусад эрсдэл	20
Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт	21
Мэргэшсэн этгээд	22
Бусад мэдээлэл	22

Энэхүү 2019 оны 8 дугаар сарын 1-ний өдрийн Удирдлагын Хэлэлцүүлэг ба Дүн Шинжилгээ (“УХДШ”) нь Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” эсвэл “Корпораци” гэх)-ийн 2018, 2019 оны 6 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон, аудит хийгдээгүй завсрын үеийн хураангуй нэгтгэсэн тайлан болон 2017, 2018 оны 12 сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон аудит хийгдсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан, тэдгээрийн тодруулуудын хамт хэрэглэгдэх бөгөөд тус Корпорацийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд хамаарна. Корпорацийн нэгтгэсэн санхүүгийн тайланг Канад доллараар илэрхийлж, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (“СТОУС”)-ын дагуу боловсруулсан.

Энэхүү хэлэлцүүлэг нь “Урьдчилсан таамаглал” гэж үзэж болохуйц тодорхой мэдэгдлүүдийг агуулсан болно. Түүхэн баримтат мэдэгдлээс бусад энэхүү тайланд дурдагдах боломжит нөөц, хайгуулын өрөмдлөг, тэсэлгээ, төсөвт санхүүгийн үр дүн, Корпорацийн хүлээж буй үйл явдал, хөгжүүлэлт зэрэг мэдэгдлүүд нь алс хэтийг угтуулан харсан мэдэгдлүүд юм. Ийнхүү урьдчилсан таамаглал (Корпораци, түүний охин компаниудын тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа, эдийн засаг, зах зээлийн ерөнхий нөхцөл байдал, ашигт малтмалын үнэ, бодит нөөц тогтоолт зэрэгтэй холбоотой төсөөллүүдийг багтаах боловч зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүй)-д тулгуурласан алсыг харсан мэдэгдлүүдэд илэрхийлсэн хүлээлтүүд нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа болохгүй бөгөөд бодит үр дүн, хөгжүүлэлт нь зах зээлийн үнэ, хайгуул ба үнэлгээний үр дүн, капитал болон санхүүгийн тасралтгүй хүртээмжтэй байдал, эдийн засаг, зах зээл, бизнесийн ерөнхий нөхцөл байдал гэх мэт хүчин зүйлээс шалтгаалан тэдгээр алс хэтийн төсөөллөөс материаллаг байдлаар ялгаатай байж болно.

Дээр тодорхойлсон эрсдэлийн хүчин зүйлс нь Корпорацид нөлөөлөхүйц бүхий л хүчин зүйлсийг хараахан бүрэн дүүрэн илэрхийлж чадахгүй. Нэмэлт хүчин зүйлсийг Корпорацийн www.sedar.com-д тавигдсан 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон Корпорацийн жилийн мэдээ, тайлангийн “Эрсдэлийн хүчин зүйлс” хэсэгт тэмдэглэсэн болно.

Канад улсын үнэт цаасны хуулиар тодорхойлогдох энэхүү УХДШ-д тусгасан санхүүгийн аливаа хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг Корпорацийн удирдлага тус УХДШ гарах өдрөөр баталсан болно. Ирээдүйтэй холбоотойгоор удирдлагын зүгээс хүлээж буй болон төлөвлөж буй ажлын талаар мэдээлэх зорилгоор санхүүгийн хэтийн төлөв, ирээдүйд чиглэсэн санхүүгийн мэдээллүүдийг өгч байгаа юм. Ийм хэтийн төлөв, ирээдүйн мэдээллүүдийг энэхүү УХДШ-д тусгаснаас бусад зорилгоор ашиглахыг хориглоно.

Компанийн танилцуулга

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 2 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын тусгай зөвшөөрлүүд дээр хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонтогийн хөрөнгийн бирж (TSX :ERD) болон Монголын хөрөнгийн биржид (MSE:ERDN) давхар бүртгэлтэй.

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн террейнд байрладаг. Энэхүү Төв Азийн Орогены бүс нь БНХАУ-ын нутагт хил дагуу болон бүсийн баруун чиглэлд эпитеpmаль алт болон порфирийн зэс-алтны ордууд сайн судлагдсан байдаг боловч Монгол улсын хувьд 1990-ээд оны дунд үеэс ардчилсан нийгэмд шилжин, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хайгуул хийх боломжийг олгосноор судлагдаж эхэлсэн. Ийнхүү судлагдсанаар дэлхийн хэмжээний алт-зэсийн орд болох Оюу Толгойг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардгаас хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Мөн Хөндий алтны төслөөс зүүн зүгт 40 км зайд Компани Зуун Мод хэмээх томоохон зэс-молибденийн төслийг нээн илрүүлсэн ба энэхүү төслийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг 100% эзэмшдэг.

2018 оны 12 сард Эрдэнэ Ресурс нь Алтан Нар, Баян Хөндий ордуудыг нэгтгэн, Хөндий Алтны Төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг (“АШЭЗТ”) боловсруулж, эдийн засгийн хувьд үр ашигтай хэмээн танилцуулсан. RPMGlobal-ын боловсруулсан энэхүү хараат бус тооцооллоор Хөндий Алтны Дүүргийн хөгжүүлэлтэд чухал ач холбогдол болохуйц анхан шатны хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал бага, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа богино төслийг хөгжүүлэх боломжтой үр дүнгүүд гарсан. Эрдэнэ Ресурс нь 2019 оны 3-р сараас эхлэн Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулж эхэлсэн.

Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн хөгжүүлэлтэд төвлөрөн ажиллаж байгаа боловч Хөндий Алтны Дүүргийн хайгуулын ажлуудыг үргэлжлүүлэн хийж байна. Хэдийгээр хайгуулын эхний шатанд явж буй боловч энэхүү дүүрэг нь суурь болон үнэт металлын систем, зэс-алтны порфирын төрлийн, дундлаг сульфидтай/ карбонат суурь металлын алтны ордууд болон бага сульфидат эпитеpmаль алт болон алт-мөнгөний системүүдийг багтааж байна.

Онцлох үйл явдлууд

Хөндий Алтны Төсөл– 100% Эрдэнэ Ресурсийн эзэмшил

- 2019 оны 8 сарын 5-нд Баян Хөндийн ашиглалтын тусгай зөвшөөрлийг авсан:
 - Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай олгогдох бөгөөд компани үргэлжлүүлэн 70 жил хүртэл сунгах боломжтой.
 - Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдлийн бэлтгэл ажил хийгдэж байна.
- Урьдчилсан ТЭЗҮ-гийн үр дүнг дэмжих нийт 1,800 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг Баян Хөндийд хийж гүйцэтгэсэн:
 - Мидфийлд бүсэд 45 г/т алтны агуулгатай 8 метрийн интервал агуулсан 5.9 г/т алтны агуулга бүхий 112 метрийн интервалыг тогтоосон.
 - Мидфийлд бүсэд газрын гадаргаас 7 метрээс эхэлсэн өндөр агуулга бүхий интервалууд илрүүлсэн. Үүнд 14 г/т алтны агуулга бүхий 14 метр интервал огтолсон.
 - Төлөвлөж буй ил уурхайн гүний хязгаараас доош 39 г/т алтны агуулга бүхий 2 метрийн интервал огтолсон бөгөөд ил уурхайн төлөвлөж буй захаас баруун зүгт 210 метрт 40 г/т алтны агуулга бүхий 3 метрийн интервал огтолсон.
 - Судалгаа хийгдэж байгаагүй шинэ бүсэд 51.9 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал огтолсон.
- Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ-г Tetra-Tech, Inc удирдан, боловсруулж байна:

- Нөөцийн тооцоолол, уурхай, геотехник, металлург, боловсруулалт, хаягдал чулуулаг болон гидрогеологийн урьдчилсан үр дүнгүүдийг хүлээн авсан.
- Боловсруулах үйлдвэр, тоног төхөөрөмжийн үнийн санал авах хүсэлтийг гаргасан.
- 2019 оны 3-р улиралд урьдчилсан ТЭЗҮ-г танилцуулан, тайланг 4-р улиралд бүртгүүлэхээр төлөвлөж байна.
- Урьдчилсан ТЭЗҮ нь Баян Хөндийн мэдээлэлд тулгуурлах ба Хөндий Алтны Төслийн техникийн тайланд багтсан Алтан Нар төслийн АШЭЗТ-ийн мэдээллүүдийг багтаана.
- Баян Хөндийн металлургийн судалгааны хөтөлбөрийг Blue Coast Research-ээр ахлуулан хийн гүйцэтгэсэн:
 - 1.07 г/т-оос 10.8 г/т алтны эх агуулга бүхий хоёр үндсэн, 13 хувьсах бүрэлдэхүүнийг шалгасан.
 - 1.0-0.5 г/л цианидийн концентрацад 48 цагийн турш уусгаснаар 92-96% алтны металл авалттай байсан бөгөөд дээжийн 80% нь 75 микрон хүртэл бутлагдсан ба 3.5 г/т алтны агуулга бүхий 93% алтны гарцтай байх төлөвтэй байна.
 - Бутлагдах шинж чанарын судалгаагаар (Bond Ball Work index, SMC, Abrasion index) Баян Хөндийн чулуулаг нь харьцангуй хатуу болон дундаж үрэгдэх чанартай байсан.
- Гидрогеологи – Боловсруулах усны хайгуулын хөтөлбөрийн хүрээнд (1,800 метр) 17 цоонг өрөмдсөн:
 - Төлөвлөсөн боловсруулах үйлдвэрээс 3 км зайд өдөрт 1,800 тонн хүдэр боловсруулах үйл ажиллагааг дэмжих боломжтой усны эх нөөц нээн илрүүлсэн.
 - Бүртгэл, тусгай зөвшөөрлүүдийг авахад шаардлагатай усны нөөцийг тодорхойлох 2-р шатны хөтөлбөрийг эхлүүлсэн.
- Sustainability East Asia LLC-аар ахлуулан, Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг (“ESIA”) боловсруулж эхэлсэн.
 - Энэхүү хөтөлбөр нь Монгол улсын Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (“БОННУ”)–ний нөхцөл, шаардлагуудаас гадна компанийн бодлого хариуцлага, тодорхой олон улсын стандартуудыг хангасан байна.
 - Орон нутагт байгаль орчин, нийгмийн мэдээлэл цуглуулах ажлыг нөлөөлөл болон удирдлагын төлөвлөгөөний дагуу 3-р улиралд эцэслэн, 3-4-р улиралд олон нийтийн хэлэлцүүлгийг зохион байгуулахаар төлөвлөж байна.
- 2019 оны 3-р улирлын хайгуулын болон техникийн хөтөлбөрийг эхлүүлсэн:
 - 9-р сард хайгуул, геотехник болон гидрологийн хээрийн судалгааны ажлууд эхэлнэ.
 - Дүүргийн хүрээнд геофизикийн судалгаа, тайллын хөтөлбөрийг хэрэгжүүлснээр тусгай зөвшөөрлийн талбайд өрөмдлөгийн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлох боломжтой.
 - Хоёрдогч зах зээл болон засгийн газрын сонгон шалгаруулалтаар хэтийн төлөв бүхий талбайг эзэмших боломжуудыг судалсаар байна.

Компанийн тухай

- 2019 оны 7 сарын 9-нд \$2,001,500 кан.долларын хаалттай санхүүжилтийг татан төвлөрүүлсэн.
 - Санхүүжилтийг урьдчилсан ТЭЗҮ боловсруулах, тусгай зөвшөөрлийн өргөдөл болон 3-р улирлын хайгуулын хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөсөн.
 - Эрдэнэ Ресурсийн удирдлага, ТУЗ-ийн гишүүд болон ажилтнууд энэхүү санхүүжилтийн 8%-ийг захиалан, хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд 2019 оны 2-р улирал эхэлснээс хойш 1.3 сая хувьцааг худалдан авсан.
- 2019 оны 4 сарын 12-нд Сэндсторм Гоулд-аас Хөндий Алтны Төслийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөр (“БЦАТ”) эсвэл “Роялти”-ийн 50%-ийг буцаан худалдан авсан:

- Хөндий Алтны Төслийн Анхан Шатны Эдийн Засгийн Тооцооллын (“АШЭЗТ”) үр дүнд үндэслэхэд БЦАТ-ийн бодит үнэ цэн нь \$1.2 сая канад доллараар буцаан худалдан авсан үнээс давна хэмээн үзэж байна.
- 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон 3 сарын хугацаанд Компанийн нийт алдагдал \$755,291 байсан нь 2018 оны мөн үеийн \$1,439,471 кан.долларын алдагдалтай харьцуулахад буурсан үзүүлэлт юм.
 - Капиталжуулсан зардлыг оролцуулсан хайгуулын зардал нь \$1,807,460 байсан бөгөөд өнгөрсөн оны \$2,462,175-тай харьцуулахад буурсан бөгөөд энэ нь Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ боловсруулахаар уурхайн судалгааны зардал өссөн, түүнтэй холбоотойгоор 2019 онд өрөмдлөг буурсантай холбоотой.
 - Компанийн захиргаа, удирдлагын зардал (мөнгөн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөр болон элэгдлийг оролцуулахгүй) нь \$261,819 кан.доллар байсан нь өнгөрсөн оны мөн үеийн \$360,616 кан.доллартай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь боловсон хүчний өөрчлөлттэй холбоотой зардал буурсан болон гүйцэтгэлийн урамшууллын хугацаатай холбоотой.

Стратеги, хэтийн төлөв

Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийг олборлолтын шат руу ахиулах болон Хөндий Алтны Дүүргийн өндөр агуулга бүхий үнэт болон суурь металлын нөөцийг тэлэх зэрэг хоёр стратегийн зорилтын дагуу ажилласан.

2019 оны 2 сард Эрдэнэ Ресурс нь Алтан Нар, Баян Хөндий ордуудыг нэгтгэн, Хөндий Алтны Төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг (“АШЭЗТ”) бүртгүүлсэн бөгөөд энэхүү тооцооллоор эдийн засгийн хувьд үр ашигтай хэмээн танилцуулсан. RPMGlobal-ын боловсруулсан энэхүү хараат бус тооцооллоор Хөндий Алтны Дүүргийн хөгжүүлэлтэд чухал ач холбогдол болохуйц анхан шатны хөрөнгө оруулалт болон үйл ажиллагааны зардал бага, хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа богино төслийг хөгжүүлэх боломжтой үр дүнгүүд гарсан. Хөндий Алтны Төслийн олборлолтыг өндөр агуулга бүхий ил аргаар олборлох боломжтой Баян Хөндийн Страйкер бүсээс эхлэн, цаашид Баян Хөндийн зэргэлдээ орших бүсүүд, түүнчлэн Алтан Нар ордод олборлолт хийхээр төлөвлөж байна.

Эрдэнэ Ресурс нь NI 43-101 тайлагналын стандартын дагуу Урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулахаар 2019 оны 3-р сараас эхлэн олон улсын инженерингийн Тетра-Тек Инк., (“Tetra-Tech Inc.”) компанитай хамтран ажиллаж байна. Хөндий Алтны Төслийн урьдчилсан ТЭЗҮ (“PFS”)-ийн хүрээнд нөөцийн тооцоолол, уурхай, геотехник, металлург, боловсруулалт, хаягдал чулуулаг болон гидрогеологийн судалгааны урьдчилсан үр дүнгүүдийг хүлээн авснаар урьчилсан ТЭЗҮ боловсруулах үйл явц нь төлөвлөгөөний дагуу явж байна. Мөн эдийн засгийн загварчлалын хүрээнд боловсруулах үйлдвэр, тоног төхөөрөмжийн үнийн санал авах хүсэлтийг явуулсан. Төлөвлөсний дагуу 2019 оны 3-р улиралд урьдчилсан ТЭЗҮ-г танилцуулна. Түүнтэй зэрэгцэн Sustainability East Asia LLC-аар ахлуулан, Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээг (“ESIA”) боловсруулж эхэлсэн.

Tetra Tech-ийн зөвлөсний дагуу компанийн удирдлага нь урьдчилсан ТЭЗҮ-г Баян Хөндий Алтны Төсөлд тулгуурлан боловсруулахаар шийдвэрлэсэн бөгөөд нөлөөлсөн хүчин зүйлс:

- Баян Хөндийн 2019 оны 2-р улирлын өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнгүүд болон түүний Баян Хөндийн нөөцийн тооцоололд үзүүлэх эерэг нөлөө;
- Тусгай зөвшөөрөл болон техникийн судалгаанаас харахад Баян Хөндийг эхний ээлжинд хөгжүүлэх нь эдийн засгийн хувьд хамгийн үр ашигтай;
- Алтан Нар төслийн өнөөгийн ордыг хөгжүүлэхээс өмнө нөөцийг тэлэх боломжийг тооцоолон, нэмэлт хайгуулын ажлыг гүйцэтгэх;
- Алтан Нар ордын суурь металл, алт авалтыг нэмэгдүүлэх, полиметаллын хүдрийг боловсруулах хамгийн тохиромжтой схем гаргахын тулд нэмэлт металлургийн судалгааг хийх шаардлагатай.

Ингэснээр Баян Хөндийн тайланг урьдчилсан ТЭЗҮ, Алтан Нарыг АШЭЗТ-ын түвшинд тайлагнана. Эдгээр судалгаануудад зориулан Tetra Tech нь Баян Хөндийн боловсруулах үйлдвэрт Алтан Нарын хүдрийг боловсруулна хэмээн таамагласан. NI 43-101 стандартын дэд бүтэц хамтран ашиглах төслүүдийг нэгтгэн тайлагнах зааварчилгааны дагуу эдгээр судалгаануудыг нэгтгэн Хөндий Алтны Төслийн техникийн тайлан болгон тайлагнана. Хөндий Алтны Төслийн техникийн тайлангийн үр дүнг 2019 оны 3-р улиралд танилцуулан, 2019 оны 4-р улиралд тайланг бүртгүүлэхээр төлөвлөсөн.

Алтан Нар нь Хөндий Алтны Төслийн гол бүрэлдэхүүний нэг хэсэг байсаар байх бөгөөд Эрдэнэ Ресурс нь нөөцийг хөгжүүлэх гол судалгаа болон тусгай зөвшөөрлийн өргөдлийн үйл явцыг үргэлжлүүлнэ.

Алтан Нар нь Хөндий Алтны Төслийн гол бүрэлдэхүүний нэг хэсэг байсаар байх бөгөөд Эрдэнэ Ресурс нь нөөцийг хөгжүүлэх гол судалгаа болон тусгай зөвшөөрлийн өргөдлийн үйл явцыг үргэлжлүүлнэ.


2019 оны 8 сарын 5-нд Монгол улсын Ашигт Малтмал Газрын Тосны Газар (“АМГТГ”) -аас Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий нөөцөд MV-021444 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон.

Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрөл нь “Монгол улсын баруун өмнө зүгт Баянхонгор аймаг дахь Баян Хөндий Алтны Төсөл” (“Bayan Khundii Gold Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia”) нэртэйгээр бүртгүүлсэн NI 43-101 эрдсийн нөөцийн техникийн тайланг багтаасан 2,309 га талбайг хамарна. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Эрдэнэ Ресурсийн Алтан Сум (“Altan Arrow”), Хойд Хөндий (“Khundii North”) болон Баруун Хөндий (“Khundii West”) хэтийн төлөв бүхий талбайнууд багтаж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай олгогдох бөгөөд компани үргэлжлүүлэн 70 жил хүртэл сунгах боломжтой. Баян Хөндийн хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой 2,205 га бүхий талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрөлд хамаарахгүй болно.

Эрдэнэ Ресурс нь 2019 оны хоёрдугаар хагаст тусгай зөвшөөрлийн талбайд Хойд Хөндий болон Алтан Сум талбайнуудад өрөмдлөгийн судалгааг хийхээр төлөвлөсөн бөгөөд Хөндий дүүргийн хүрээнд тусгай зөвшөөрлийн талбайг нэмэгдүүлэх боломжийг судалж байна. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, 20 гаруй хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон. Мөн 2018 оны сүүлээр Монгол улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож эхэлсэнтэй холбоотойгоор Компанийн сонирхож буй талбайд сонгон шалгаруулалт зарлагдах тохиолдолд идэвхтэйгээр оролцоно.

Хайгуул болон хөгжүүлэлтийн шатны төслүүд

Монгол улсын баруун өмнөд бүсэд орших Эрдэнэ Ресурсийн Хөндий Алтны Дүүрэг



2018 оны 9-р сарын 15-нд Компани нь Хөндий алтны төслийн анхан шатны нөөцийн тооцооллыг танилцуулсан. Зуун Модын ордоос бусад Компанийн эзэмшлийн хайгуулын талбай нь хайгуулын эхний шатанд явж буй бөгөөд NI 43-101 тайлагналын стандартын дагуу тайлагнах нөөцийн тайланг боловсруулаагүй байна. Дээр дурдсан ордуудаас гадна энэхүү Удирдлагын хэлэлцүүлэг ба дүн шинжилгээнд дурдсан талбайн боломжит агуулга болон хэмжээ нь урьдчилан таамагласан таамаглал бөгөөд нөөцийн тайланг боловсруулах хэмжээний хайгуулын судалгаа хийгдээгүй байгаа болно. Компанийн төслүүдийн тухай нэмэлт мэдээллийг www.sedar.com, SEDAR дахь компанийн хуудсаас NI 43-101 техникийн тайлан, жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлүүдээс (“AIF”) авч танилцах боломжтой.

Хөндий Алтны Төсөл

Хөндий Алтны Төсөл нь Компанийн өндөр агуулга бүхий Баян Хөндий, Алтан Нар ордуудаас бүрддэг. Компанийн 100% эзэмшил бүхий Баян Хөндий (“Rich Valley”) алтны орд нь Монгол улсын баруун өмнө зүгт, Баян Хөндийн нөөцийг агуулсан 2,309 га ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбай, 2,205 га Хөндий хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайг хамардаг. 2019 оны 8 сарын 5-нд Монгол улсын Ашигт Малтмал, Газрын Тосны Газар (“АМГТГ”) - аас Эрдэнэ Ресурсийн Баян Хөндий нөөцөд MV-021444 дугаар бүхий ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон. Энэхүү ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 2018 оны 11 сарын 1-нд RPMGlobal Asia Limited боловсруулж, “Монгол улсын баруун өмнө зүгт Баянхонгор аймаг дахь Баян Хөндий Алтны Төсөл” (“Bayan Khundii Gold Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia”) нэртэйгээр бүртгүүлсэн NI 43-101 эрдсийн нөөцийн техникийн тайланг багтаасан 2,309 га талбайг хамарна. Түүнээс гадна ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд Эрдэнэ Ресурсийн Алтан Сум (“Altan Arrow”), Хойд Хөндий (“Khundii North”) болон Баруун Хөндий (“Khundii West”) хэтийн төлөв бүхий талбайнууд багтаж байна. Ашиглалтын тусгай зөвшөөрөл нь 30 жилийн хугацаатай олгогдох бөгөөд компани үргэлжлүүлэн 70 жил хүртэл сунгах боломжтой. Баян Хөндийн хайгуулын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын хөтөлбөр хэрэгжүүлэх боломжтой 2,205 га бүхий талбай нь ашиглалтын тусгай зөвшөөрөлд хамаарахгүй болно. Хөндий хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 10 дахь жилдээ хүчинтэй байгаа бөгөөд 12 жилийн хугацаа дуусахаас өмнө Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой.

Компанийн 100% эзэмшил бүхий Баян Хөндий алтны ордыг 2015 оны 2 дугаар улиралд нээж илрүүлэн 2015 оны 4-р улиралд анхны өрөмдлөгийг хийж, эхний цооноогоос 14 метрийн гүнд 27.5 г/т алтны агуулгатай 7 метр зузаантай интервал илрүүлсэн. Баян Хөндий нь алтны өндөр агуулгатай, гадаргад ойр, хялбар металлургийн нөхцөлтэй тул Корпорацийн голлон төвлөрөх төсөл болоод байна. Компани нь Баян хөндийд нийтдээ 42,656 тууш метр бүхий 255 алмазан цооног өрөмдөөд байгаа юм. Өнөөг хүртэл хийсэн өрөмдлөгөөр эрдэсжилт нь гадаргаасаа эхэлдэг Страйкер бүс, залуувтар, хүдэржилтийн дараах Цэрдийн хучаас доор зүүн хойш сунаж тогтсон Мидфийлд болон Хойд Мидфийлд бүс гэсэн үргэлжлэх магадлал өндөртэй, өндөр агуулгатай алтны эрдэсжилт бүхий 3 гол цэгийг олж тодорхойлсон. Энэ гурван бүсийн хоорондох алт агуулагч бүсүүд нь өргөн, 110 метрээс илүү интервалд 6 г/т алтны илэрцтэй байж болзошгүй.

2017 онд хийсэн хэмжээст өрөмдлөгөөр Страйкер бүсээс зүүн хойш 200м зайтай орших Мидфийлд бүсэд тохиолдсон эрдэсжилт нь залуувтар хучдасын доогуур багадаа 280м цааш сунан тогтсон байв. Одоогоор Баян Хөндийн Мидфийлд болон Хойд Мидфийлд бүсүүдээс 42 метрийн гүнд 80 метр 6.0 г/т алтны илэрц бүхий BКD-98, 1 метр 2,200 г/т алтны илэрц бүхий 14 метр 158 г/т алтны агуулгатай BКD-231 гэх мэт хамгийн өндөр агуулга бүхий эрдэсжсэн интервалууд илрээд байна.

2019 оны 4-р сард гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөр нь урьдчилсан ТЭЗҮ-д тусгагдах мэдээллийг баталгаажуулах, Мидфийлд, Хойд Мидфийлд бүсүүдийн гол хүдэржилтийг тэлэх болон өндөр агуулгатай хүдрийн бүсийг шалгахад чиглэсэн нийт 1,800 метрийн өрөмдлөгийн хөтөлбөр байсан. Энэхүү өрөмдлөгийн хөтөлбөрөөр Мидфийлд бүсэд 112 метрийн интервалтай 5.9 г/т алт огтолсон нь одоогоор Баян Хөндийн өрөмдлөгийн хамгийн сайн үр дүнгүүдийн нэг болоод байгаа ба Баян Хөндийн төв хэсэгт газрын дөт гүнд, өндөр агуулгатай хүдэржилтийн үргэлжлэлийг баталгаажууллаа. Мөн одоогийн нөөцийн хязгаараас гадагш Баян Хөндийн урд талд хүдэржилтийн цар хүрээг тэлсэн бөгөөд 51.9 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал гүнд огтлогдсон (BКD-266).

Компанийн 100% эзэмшил бүхий Алтан Нар (“Golden Sun”) орд нь Баян Хөндий ордоос баруун хойд зүгт 16 км-т орших Цэнхэр Номин тусгай зөвшөөрлийн талбайд 4,669 га талбайг хамран оршдог. Хайгуулын тусгай зөвшөөрөл нь 12 жилийн 10 дахь жилдээ хүчин төгөлдөр байгаа бөгөөд Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу хайгуулын тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөл болгох боломжтой. Тусгай зөвшөөрлийн талбай нь 5.6 x 1.5 км хүдэржилттэй корридор эрдэсжсэн 18 (алт, мөнгө, хар тугалга, цайр) хэтийн төлөвт талбайг агуулдаг. Анхны хоёр нээлт болох “Нээлтийн бүс” (“НБ”) болон “Хойд Холбоос” (“ХХ”) бүсүүд нь Эрдэнэ Ресурсийн 2018 оны 2-р улиралд гаргасан нөөцийн шинэчилсэн тайланд мэдээлснээр хамгийн ихээр судлагдсан газрын гадаргууд дөт гүнд өндөр агуулгатай бүсүүдийг агуулдаг. 2018 оны 2-р улирлын ашигт малтмалын нөөцийн шинэчилсэн тайланд 16 хэтийн төлөв бүхий талбайн үр дүнг тусгасан. Компани эдгээр талбайг хайгуулын анхан шатны төсөл хэмээн үзэж байгаа ба өндөр агуулгатай эрдэсжилт илрэх хэтийн төлөвтэй гэж үзэж байна.

Эрдсийн нөөц

Эрдэнэ Ресурс нь 2018 оны 9-р сарын 12-нд RPMGlobal Asia Limited (“RPM”) -ийн боловсруулсан Хөндий Алтны Төслийн анхан шатны нөөцийн NI 43-101 техникийн тайлангийн үр дүнг олон нийтэд танилцуулсан). Хөндий Алтны Төслийн нөөцөд Баян Хөндий ордын анхан шатны эрдсийн нөөцийн

тооцоолол болон Алтан Нар ордын 2018 оны 5-р сард тайлагнасан нөөцийг нэмэгдүүлсэн NI 43-101 Нөөцийн тайлагналын тайлангийн мэдээлэл багтсан. Нөөцийн тооцоолол нь 2015 оны 4-р улирлаас 2018 он 2-р улиралд хийсэн 42,656 метрийн 255 алмазан өрмийн цооногийн үр дүнг багтаасан. Мөн нөөцийн тайлан нь 1.2 км урт (Зүүн хойноос Баруун өмнө зүгт) болон 200-400 метр өргөн (Баруун хойноос Зүүн өмнө зүгт) талбайд газрын гадаргад ойр, өндөр эрдэсжсэн (2,200 г/т хүртэл алтны агуулга) системийг хамарсан. Баян Хөндийн нөөцийн тооцоололд өндөр агуулга бүхий хүдрийн бүсийн (8 г/т-оос 250 г/т хүртэл) дундаж агуулгын дээд хязгаарыг 51 г/т, харин бага агуулга бүхий хүдрийн бүсийн дундаж агуулгын дээд хязгаарыг 1.5 г/т агуулгаар тооцсон.

Захын агуулгын хувилбаруудад хийсэн нөөц агуулгын хамаарлын мэдрэмтгий байдлын шинжилгээний үр дүнг доорх хүснэгтэд харуулав¹:

Захын агуулга ²	Нөөцийн тодруулга	Хэмжээ (сая тонн)	Алтны агуулга (г/т)	Алтны унц (000)	AuEq агуулга (г/т)	AuEq унц (000)
0.2	Баттай & Бодит	23.6	1.2	904	1.4	1,046
	Боломжит	16.8	0.8	416	1.0	511
0.4	Баттай & Бодит	15.1	1.7	824	2.0	965
	Боломжит	8.6	1.2	342	1.6	436
0.6 / 0.7³	Баттай & Бодит	10.1	2.3	751	2.7	886
	Боломжит	5.2	1.8	291	2.3	382
1.0	Баттай & Бодит	6.8	3.1	678	3.7	803
	Боломжит	3.9	2.1	261	2.9	349
1.4	Баттай & Бодит	5.5	3.7	642	4.3	755
	Боломжит	3.4	2.3	250	3.0	333

(1) Баян Хөндий болон Алтан Нарын нэгтгэсэн нөөц

(2) Алтан Нарын нөөцийн захын агуулга нь алттай дүйцэх нэгжээр, Баян Хөндий нь зөвхөн алтаар хэмжигдсэн.

(3) RPMGlobal нь Баян Хөндийн ил уурхайн нөөцийг 0.6 г/т, Алтан Нарын ил уурхайн нөөцийг 0.7 г/т харин ил уурхайгаас доош орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор тооцоолохыг зөвлөсөн.

Анхан Шатны Эдийн Засгийн Тооцоолол

2018 оны 12 сарын 18-нд Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд бүсэд байрлах өөрийн 100% эзэмшлийн Хөндий Алтны Төсөл (“Төсөл”)-ийн хараат бус Анхан Шатны Эдийн Засгийн Тооцоолол (“АШЭЗТ”)-ын үр дүнг танилцуулсан. АШЭЗТ-ыг RPMGlobal Asia Limited (“RPM”) нь National Instrument 43-101 (“NI 43-101”) эрдсийн нөөцийн тайлагналын стандартын дагуу боловсруулсан.

Анхан шатны эдийн засгийн тооцооллоор өндөр агуулга бүхий ил аргаар олборлох боломжтой Баян Хөндий төслийн Страйкер бүсээс эхлэн олборлож, цаашид Баян Хөндийн зэргэлдээ орших бүсүүд болон Алтан Нар төслийн талбайд олборлолт хийхээр төлөвлөж байна. Хөгжүүлэлтийн төлөвлөгөөнд уламжлалт нүүрсэнд уусгах технологи болон гравитациар баяжуулах аргаар өдөрт дунджаар 1,800 тонн хүдэр боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөгдсөн.

Баян Хөндий орд нь 3.65 г/т дундаж агуулга бүхий 2.7 сая тонн хүдрийн нөөц, үүний 98%-ийг баттай ба бодит ангиллын нөөцийн хүдэр бүрдүүлж байна. Алтан Нар орд нь 3.11 г/т дундаж агуулга бүхий 1.9 сая тонн хүдрийн нөөцтэй, үүний 70%-ийг баттай ба бодит ангиллын хүдрийн нөөц бүрдүүлж байна.

Энэхүү АШЭЗТ-ыг боловсруулахад ашиглагдсан мэдээллийн тодорхой хэсэг нь геологийн таамаг баялаг дээр суурилсан болно. Ашигт малтмалын геологийн баялаг нь эрдсийн нөөц биш бөгөөд эдийн засгийн хувьд илүү эрсдэлтэй ангилал юм. Энэхүү АШЭЗТ нь бүрэн хэрэгжих баталгаагүй болно.

Тооцооллын голлох үзүүлэлтүүдийг доорх хүснэгтэд харуулав:

Төсөөлөл		
Алтны үнэ	US\$/унц	1,200
Олборлолт		
Уурхайн ашиглалтын хугацаан дахь хүдрийн дундаж агуулга ¹	г/т алт	3.42
Төслийн хугацаа ²	жил	11
Уурхайн ашиглалтын хугацаа	жил	8
Өдөрт боловсруулах хүдрийн хэмжээ ³	тонн	1,800

Жилд олборлох алтны хэмжээ	унц	51,200
Жилд олборлох алтны дээд хэмжээ	унц	68,100
Ашиглалтын хугацаанд олборлох нийт алт	унц	412,000
Ашиглалтын хугацааны дундаж металл авалт	%	82%
Хөрс хуулалтын харьцаа ("Strip ratio")	тонн: тонн	10.5:1
Нэг унц алт үйлдвэрлэх зардал ("AISC") ⁴	US\$/унц	714

Төслийн эдийн засгийн үзүүлэлтүүд		
Татварын өмнөх бодит үнэ цэн		
5% хорогдуулалт бүхий ("NPV5%")	сая ам.дол	135
7.5% хорогдуулалт бүхий ("NPV7.5%")	сая ам.дол	119
10% хорогдуулалт бүхий ("NPV10%")	сая ам.дол	105
Татварын дараах бодит үнэ цэн		
5% хорогдуулалт бүхий ("NPV5%")	сая ам.дол	99
7.5% хорогдуулалт бүхий ("NPV7.5%")	сая ам.дол	86
10% хорогдуулалт бүхий ("NPV10%")	сая ам.дол	76
Дотоод өгөөжийн түвшин болон буцаан төлөх хугацаа		
Татварын өмнөх дотоод өгөөжийн түвшин ("IRR")	%	70%
Татварын дараах дотоод өгөөжийн түвшин ("IRR")	%	56%
Эргэн төлөх хугацаа ⁵	жил	1.8
Капиталын нөхцөлүүд		
Тооцоолоогүй зардал багтсан олборлолтын өмнөх зардлууд	сая ам.дол	32
Ашиглалтын хугацааны хөрөнгө оруулалтын зардлууд	сая ам.дол	8

(1) Хүдрийн дундаж агуулга

(2) Төслийн хугацаанд уурхай байгуулах 1 жил, олборлолт хийх 8 жил болон уурхайн хаалтын 2 жил багтсан

(3) Үйлдвэр нь жилд 8,000 цаг ажиллаж, жилд 600,000 тонн хүдэр боловсруулах хүчин чадалтай байна

(4) Үйл ажиллагааны зардал нь цутгасан алтаар тайлагнагдан, US \$62/унцаар тооцологдсон Монгол улсын Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр ("АМНАТ") болон цэвэршүүлэх зардлууд багтсан

(5) Эргэн төлөх хугацааг татварын дараах хорогдуулалт хийгээгүй мөнгөн гүйлгээнд тулгуурлан тооцоолсон

Доорх хүснэгтэд алтны үнээс шалтгаалан татварын дараах өнөөгийн үнэ цэн ("NPV") болон дотоод өгөөжийн түвшин ("IRR") хэрхэн өөрчлөгдөхийг харуулав. Үзүүлэлтүүд алтны үнийн өсөлт бууралтад төслийн уян хатан байдал ямар байгааг харуулж байна.

Мэдрэмтгий чанарын судалгаа	Нэгж	US\$1,150	US\$1,200	US\$1,250	US\$1,300
NPV (5% хорогдуулалт бүхий)	сая ам.дол	86	99	111	124
NPV (7.5% хорогдуулалт бүхий)	сая ам.дол	75	86	98	110
NPV (10% хорогдуулалт бүхий)	сая ам.дол	65	76	86	97
IRR	%	50%	56%	62%	68%

АШЭЗТ-оор уурхай нь жилд 600,000 тонн хүдрээр үйлдвэрийг тэжээхээр төлөвлөгдөж байна. Олборлох боломжтой хэмжээг 4.6 сая тонн, үүнд 3.42 г/т дундаж агуулга бүхий хүдэр багтсан бөгөөд хөрс хуулалтын харьцаа 10.5:1 байна. (тонн хаягдал: тонн үйлдвэр тэжээх хүдэр)

АШЭЗТ-д хүдрийг боловсруулахдаа уламжлалт буюу гравитациар баяжуулан, нүүрстэй уусгах технологиор алтыг ялгаж авахаар төлөвлөсөн. Хүдэр боловсруулах үйлдвэрийг Баян Хөндийн ил уурхайтай зэрэгцээ барих бөгөөд өдөрт 1,800 тонн хүдэр боловсруулна. Төслийн хугацаанд дундаж металл авалт 82% байх ба нийт 412,000 унц алт олборлохоор төлөвлөсөн.

Үйл ажиллагааны зардал нь дээр дурдсан олборлолтын болон боловсруулалтын хувилбар дээр үндэслэж тооцоологдсон, ингэхдээ гэрээт олборлогчтой ажиллахаар төлөвлөв. Бусад бүх үйл ажиллагааг компани өөрөө хариуцан ажиллана. Ашигт Малтмалын Нөөц Ашигласны Төлбөр болон түүнтэй холбоотой зардлаас бусад зардал дээр тооцоологдоогүй 10%-ийн зардал нэмэгдсэн. Нэг унц алт үйлдвэрлэх зардал \$714 ам.доллар байна.

Зардлууд	Уурхайн ашиглалтын хугацаанд		
	сая ам.дол	US\$/унц	US\$/тонн
Уурхайн үйл ажиллагааны зардал	134	326	29
Боловсруулалтын зардал	76	183	16
Уурхайн захиргаа, удирдлагын зардал	30	73	7
Бүтээгдэхүүний зардал	2	6	1
Нөөц ашигласны төлбөр ба бусад зардал	26	62	6
Тооцоологдоогүй зардлууд	24	58	5
Нийт үйл ажиллагааны зардал	292	708	64
Ашиглалтын үеийн хөрөнгө оруулалт	3	6	1
Нэг унц алт үйлдвэрлэх зардал	295	714	65

Уурхай байгуулалт, боловсруулах үйлдвэр болон холбогдох дэд бүтцийн анхан шатны хөрөнгийн зардлыг (0 жилд) 32 сая ам.доллар хэмээн тооцоолсон. Хэрэв түрээсийн тоног төхөөрөмжийг худалдан авах шаардлага гарвал хөрөнгийн зардал дээр 38 сая ам.доллар нэмэгдэнэ. Боловсруулах үйлдвэр болон холбогдох байгууламжууд Баян Хөндийд байрлана. 3 дахь жилээс эхлэн Алтан Нартай холбох дэд бүтэц нь 1 сая ам.долларын өртгөөр бүтэх бөгөөд дээрх бүх зардлууд дээр нэмж 20% тооцоолоогүй зардал багтсан.

Уурхайн төлөвлөлтөд 3 сая ам.доллар, уурхайн хаалтад 4 сая ам.долларын тогтвортой хөрөнгийг тусгасан. Төслийн ашиглалтын хугацааны нийт хөрөнгийн зардлыг 40 сая ам.доллараар тооцоолсон.

Зардал	Баян Хөндий (сая ам.дол)	Алтан Нар (сая ам.дол)	Нийт (сая ам.дол)
Баяжуулах үйлдвэр	16	-	16
Барилга байгууламж	3	-	3
Байр, орон сууц	2	-	2
Нислэгийн зурвас	1	-	1
Зам	1	1	2
Мэргэжлийн ажил үйлчилгээ	4	-	4
Мэргэжлийн үйлчилгээнд тооцоогүй зардал	5	-	5
Үйлдвэр ба дэд бүтэц	32	1	33
Уурхайн хаалт	3	1	4
Тогтвортой хөрөнгө оруулалт	2	1	3
Нийт	37	3	40

Хөндий Алтны Төслийн үнэ цэнийг нэмэгдүүлэх боломжууд:

- **Өндөр агуулга:** Энэхүү орд нь өндөр агуулга бүхий орд тул цаашид олборлолтын шатанд тооцоолсноос өндөр агуулга бүхий бүсийг нээн илрүүлэх магадлалтай гэж үзэж байна. Анхан шатны эдийн засгийн тооцоололд блок загварт хамгийн өндөртөө 55 г/т алтны агуулга багтсан. Харин өрөмдлөгийн судалгааны үед 50 г/т-оос 2200 г/т хүртэл 40 гаруй интервалуудыг огтолсон.
- **Баян Хөндийн нэмэлт нөөц:** Анхан шатны эдийн засгийн тооцоололд төлөвлөсөн ил уурхайн бүсэд ороогүй хэсэгт дунджаар 4 г/т алтны агуулга бүхий 60,000 унц бодит, 70,000 унц боломжит нөөц байна. Энэхүү нөөц нь Баруун Страйкер бүсэд, уурхайн хананаас 100 метрийн орчимд 100 метрийн гүнд оршиж байна. Ирээдүйд энэхүү нөөцийг далд аргаар олборлох талаар судалгаа хийгдэнэ.
- **Алтан Нарын нэмэлт нөөц:** Алтан Нард тооцоологдсон дийлэнх нөөц нь энэхүү анхан шатны эдийн засгийн тооцоололд бүрэн тусгагдаагүй. Ирээдүйн хөгжүүлэлтэд багтаахад нэмэлт өрөмдлөг болон металлургийн судалгаа хийх шаардлагатай.
- **Хайгуулын боломж:** Баян Хөндий болон Алтан Нар ордууд нь хайгуул бага хийгдсэн, хэтийн төлөв өндөр бүсэд оршдог. Компани нь энэхүү бүс дэх хамгийн том хайгуулын мэдээллийн санг эзэмшдэг бөгөөд цаашид хайгуулын судалгаа хийх болон тусгай зөвшөөрлийн талбай худалдан авах замаар нөөц нэмэгдүүлэх боломжтой.
- **Металл авалтыг нэмэгдүүлэх:** Баян Хөндийн хүдэржилтээс харахад металл авалт дунджаар 92% байна. Мөн өндөр агуулга бүхий хүдрийг уусгах аргаар шалгаж үзсэн бөгөөд металл авалт 99% хүртэл өссөн. Цаашид нэмэлт металлургийн судалгаа хийснээр металл авалтыг нэмэгдүүлэх боломжтой. Алтан Нар ордын хувьд хүнцлийн колчеданы хүдэр багтаж

байгаа тул дундаж металл авалт 62% байна. Алтан Нарын Нээлтийн бүсийн дээжийг уусгах аргаар дахин шалгахад металл авалт 88% хүртэл нэмэгдэх боломжийг харуулсан, үүнтэй холбоотойгоор ирээдүйд нэмэлт металлургийн судалгааг хийнэ.

- **Уурхайн төлөвлөлт:** Анхан шатны эдийн засгийн тооцооллоор Хөндий Алтны Төслийн уурхайн үйл ажиллагааг эхлүүлэх талаар эхний алхмуудыг танилцуулсан. Цаашид уурхайн төлөвлөлтийг сайжруулах, хаягдал зөвөөрлөлт, бохирдлыг бууруулах, ашиглалтын техникийн аргачлалыг сайжруулах зэргээр зардлыг бууруулах боломжуудыг судална.
- **Уурхайн тоног төхөөрөмжийн сонголт:** Голлох бус тоног төхөөрөмжийг 2-р зэргийн ханган нийлүүлэгчээс авч хөрөнгө, үйл ажиллагааны зардлыг бууруулах аргыг судлах боломжтой.
- **Сонгон шалгаруулалт:** Монгол улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яам нь хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож эхэлсэн бөгөөд 2019 онд хэтийн төлөв бүхий тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтад оролцох боломжтой. Компани нь хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг тодорхойлсон бөгөөд энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна.

Дүүргийн хэмжээний хайгуул

Эрдэнэ Ресурс нь Эдрэнгийн Нурууны дагуу тусгай зөвшөөрлийн талбайд эрдэсжсэн бүсэд хайгуулын боломжийг эрэлхийлэн ажилласаар байна. Энэхүү хайгуулын хөтөлбөрийн дагуу Компанийн 5 тусгай зөвшөөрлийн талбайд хэд хэдэн хэтийн төлөв бүхий талбайг илрүүлэн өрөмдлөгийн ажлыг эхлүүлэх, сонгон шалгаруулалтын хүрээнд нэмэлт талбайн тусгай зөвшөөрлийг Засгийн Газраас авах зэрэг ажлуудыг төлөвлөсөн.

Тусгай зөвшөөрлийн талбайд хийсэн хайгуулын ажлын хүрээнд алтны эрдэсжсэн бүсүүдийг нээн илрүүлээд байна. Өрөмдлөгийн ажлаар нийт цооногийн 70% нь алтны эрдэсжилт бүхий гажилтыг огтолсон (>0.1 г/т алтны агуулгатай), үүнээс гуравт нь 20 г/т алтны агуулгатай 1-2 метрийн интервалууд илэрсэн. Бүс нутгийн хайгуулын өрмийн судалгааг газрын дөт гүнд буюу дунджаар 100 метр гүнд өрөмдлөг хийсэн. Орчин үеийн хайгуулын судалгаа хийгдээгүй бүсэд газрын дөт гүнд хийсэн геохимийн болон геофизикийн судалгааны эерэг дүнд тулгуурлан энэхүү өрмийн судалгааг хийх болсон. Газрын дөт гүнд хийсэн хайгуулын судалгаа, гурван ордын газрын гадаргад ойр байдал зэрэг нь энэхүү шинэ дүүрэг нь нээлтийн өндөр боломж, хэтийн төлөвийг агуулж байна гэж үзэхэд хүргэж байна.

Өмнөд Баян Хөндий бүс

Өмнөд Баян Хөндий нь Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд, Баян Хөндий алтны ордоос баруун өмнө зүгт 250 метрт байрладаг. 2019 оны эхээр хийсэн нөөцийг тэлэх өрөмдлөгөөр өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийг (51 г/т алтны агуулга хүртэл) илрүүлсэн бөгөөд (BKD-266) цооног нь одоогийн Баян Хөндийн нөөцийн хязгаараас гадна байрлаж байна. Урьд нь хайгуулын өрөмдлөг хязгаарлагдмал хийгдэж байсан талбайд өндөр агуулга бүхий алтны судлууд өмнө зүгт үргэлжилж буйг тогтоосон. Энэ бүсэд хийгдэж буй IP туйлт геофизикийн судалгаанд төвлөрөхөөс гадна Компани нь Өмнөд Баян Хөндий бүсэд алтны өндөр агуулга бүхий судлууд үргэлжилж буйг шалгах өрөмдлөгүүдийг хийхээр төлөвлөж байна.

Алтан Сум алтны төсөл

Алтан Сум талбай нь Хөндий тусгай зөвшөөрлийн талбайн гол хэсэгт Баян Хөндий ордоос хойд зүгт 3.5 км зайд оршдог. Энэхүү талбайн өрөмдлөгийн судалгаа нь талбайн гол структурын өндөр агуулгыг огтолсон өмнө бүсэд төвлөрсөн, үүнд 39 г/т алтны агуулга бүхий 1м интервал, 70 г/т алтны агуулга бүхий 2м интервал огтлогдсон. Алтан Сумд өрөмдсөн нийт 20 цооногийн (2,552 тууш м) 85% нь алтны эрдэсжилт огтолсон.

Эрдэнэ Ресурс нь гол структурыг трендийн дагуу тэлэх зорилгоор 1,412 тууш метрийн урттай 10 цооногийн өрөмдлөгийг 2018 онд хийсэн. Алтан Сум дахь алтны эрдэсжилт бүхий талбайг тэлэх зорилгоор өрөмдсөн цооног (AAD-18) нь хүдэржилтийн суналыг баруун зүгт 500 метрээр тэлж, 2-4 метрийн өргөн эпитеpmаль кварц судлууд болон штокверк брекчийн бүсүүдэд 1.3 г/т хүртэл алтны агуулга илрүүлсэн. Өнөөгийн өрөмдлөгийн судалгаагаар нийт 1.2 км (суналын дагуу нээлттэй) урттай талбайд алтны эрдэсжсэн коридорыг үүсгэж буйг тогтоосон бөгөөд хүдрийн биет байх магадлалтай хэсгээс өмнө зүгт 400 метрт мөн алтны эрдэсжилт илрүүлээд байна. Мөн өмнөд хэсэгт байх структурын салааг өрөмдсөн өрөмдлөгийн ажлаар 0.2- 2.6 г/т алтны агуулгатай мөнгө, молебдин, хар тугалга, цайр болон сурьмагийн аномаль агуулгуудтай олон зузаалгийг (AAD-25) гүнд (бодит гүн нь ойролцоогоор 100 метр) огтолсон. Хайгуулын судалгааны үр дүнгээс үзэхэд дүүрэг дэх алтны эрдэсжилт нь структурын огтлол болон тэлэх чадвар бүхий гол бүсүүдээр хянагдсан байна. Эдгээр бүсүүд нь хувирлаас үүдэлтэй магнетитийн задралтай холбоотой, соронзон шинж чанар багатай

бүсүүдийг бий болгосон. Компани нь ирээдүйд хийхээр төлөвлөсөн өрөмдлөгийн ажлаас урьтаж эдгээр хувирлын бүсүүдэд өндөр нягтаршил бүхий соронзон хайгуулыг хийж гүйцэтгээд байна.

Хойд Хөндий

Хойд Хөндий талбай нь Баян Хөндий ордоос зүүн хойд зүгт 4 км-т оршдог бөгөөд 2018 онд анхны өрөмдлөгийн ажлыг хийсэн. 2017 онд хийсэн гадаргуун хайгуулын зураглалын үр дүнд энэхүү талбайг илрүүлсэн бөгөөд 650 метр урт үргэлжилэх структураар хянагдсан кварцын штокверк болон брекчийн судлын бүсээс дээжилсэн кварцын судлын биетэд 22 г/т хүртэл өндөр агуулга бүхий алтны хүдэржилт илэрсэн. Дунджаар 93 метрийн босоо гүнтэй нийт 656 тууш метрийн урттай 5 цооногоор тус структурыг шалгасан ба 3-ыг нь урд хэсэгт, 2-ыг нь хойд хэсэгт 500 метрийн зайтайгаар өрөмдсөн. Хойд хэсэгт хийсэн өрөмдлөгийн үр дүнгээр зөвхөн бага хэмжээний алтны эрдэсжилтийг огтолсон бол урд хэсэгт өрөмдсөн 3 цооног нь олон үе шаттай эпитеpmаль кварцын штокверк болон брекчийг хувирсан монзонитод огтолсон. Эдгээр штокверк бүсүүд нь тасралтгүй үргэлжлэх ба 35 м хүртэлх зузаантай (AAD-29) бөгөөд зарим хэсэгт 1 метрийн зузаалаг бүхий 2.1 г/т (AAD-30) хүртэлх алтны аномаль утга мөн хэсэгчлэн тохиолдох зэсийн аномаль (>500ppm) илэрсэн. Хойд Хөндий талбай нь ирээдүйн хайгуулын хувьд өндөр боломж, хэтийн төлөвтэй талбай юм.

Төв Структурын Бүс

2018 оны 3-р улиралд Компани нь Баян Хөндий ордоос баруун хойд зүгт 800 метрт шинэ талбайд өрөмдлөг хийсэн. Төв Структурын Бүс ("ТСБ") талбайд гадаргуун гарш хязгаарлагдмал байдаг ба талбайг Баян Хөндий ордтой төстэй хувиралтай, геофизикийн хувьд мөн ижил төстэй, гадаргын хайгуул бага хийгдсэн тул өрөмдлөгийн судалгаа хийхэд тохиромжтой талбай гэж үзсэн. Уг талбайд 75 метрийн дундаж гүнтэй 3 гүехэн цооногийг (AAD-31-33) 500 метрийн урттай чиглэл дагуу өрөмдсөн. Хэдийгээр галт уулын агуулагч чулуулагт огтлогдсон кварцын судлууд болон гематит/спекулярит судланцарууд нь Баян Хөндийн голлох бүсүүдийнхтэй төстэй байсан боловч алтны аномаль агуулга илрээгүй. Энэ талбайд тохиолдох шаврын хувирлыг смектит гэж тогтоосон бөгөөд энэ нь энэ талбайг Баян Хөндийд ажиглагддаг илүү өндөр температурын иллит агуулагч алтны бүсүүдийн зах хязгаар байх боломжтойг харуулсан. Хувиралгүй галт уулын чулуулаг энэ бүсийг Баян Хөндийгөөс тусгаарлаж байгаа нь ТСБ бүс нь алтны хүдэржилттэй илүү өндөр температурын иллитийн шаврын дээр орших дөт гүний эртний тогтоц байх боломжтой гэсэн дүгнэлтэнд хүргэсэн. Нэмэлт структур, геофизик болон хувирлын зураглалыг энэхүү талбайд хийж байгаа ба ингэснээр илүү гүний цооног өрөмдөх шаардлагатай эсэхийг тогтоох юм.

Улаан зэс-алтны порфирын төсөл

Компани нь 2017 оны 8-р сарын 30-нд Баян Хөндий алтны төслийн баруун зүгт орших Улаан хайгуулын тусгай зөвшөөрлийн 51%-ийг 100% хүртэл худалдан авах нөхцөлтэйгөөр худалдан авсан. Улаан талбай нь 1,780 га талбайг хамардаг бөгөөд 3 км диаметр бүхий гүндээ зэсийн порфир болон эпитеpmаль алтны системтэй холбоотой байж болохуйц хүчтэй хувирсан бүсэд оршдог. Энэ хайгуулын тусгай зөвшөөрөл нь хайгуулын тусгай зөвшөөрлийн 12 жилийн 4 дэх жилдээ явж байгаа бөгөөд Монгол улсын Ашигт малтмалын тухай хуулийн дагуу тусгай зөвшөөрлийн хугацаа дуусахаас өмнө ашиглалтын тусгай зөвшөөрөлд шилжүүлэх боломжтой. Энэхүү төслийн 51%-ийг худалдан авах гэрээ байгуулснаас хойш 3 жилийн турш \$600,000 ам.долларын хайгуулын судалгааг энэхүү талбайд хийснээр үлдсэн 49%-ийг тухайн үеийн үнэлгээгээр худалдан авах эрх үүснэ. Эрдэнэ Ресурс энэхүү 3 жилийн опционы хугацааг жилд \$100,000 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулснаар сунгах боломжтой.

Улаан талбайд гадаргуун чулуун дээжлэлт болон урсгал сарнилын хүрээний дээжлэлт хийн, алт, зэс болон молибденийн хэд хэдэн хуримтлал бүхий гажил байгааг тогтоосон. Мөн геофизикийн судалгаа хийж цаашид үргэлжлүүлэн судлах хэд хэдэн хэтийн төлөвт бүсийг тогтоосон.

Энэхүү талбайд 2018 оны 3-р улиралд анхан шатны хайгуулын өрөмдлөг хийсэн бөгөөд тусгай зөвшөөрлийн төв хэсэгт 1.3 км талбайд нийт 1,050 тууш метрийн урттай 3 цооногийг өрөмдсөн. Гурван цооног гурвуулаа галт уулын чулуулагт хэсэгчлэн орших, зэсийн ахиу агуулгатай кварц-пиритийн зэрэгцээгээс штокверк судлуудыг огтолсон ба мөн газрын гадарга дээрх пропицитийн хувирлаас газрын гүн дэх филлик (кварц-серицит-пирит) хувирлын тодорхой ялгагдах бүсчлэлийг огтолсон. Эдгээрийн хамгийн баруун талын цооногоор хүндийн хүчний эерэг гажил болон 300 м хүртэлх гүний цахилгаан цэнэгжих гажлуудын давхцалыг шалгасан. Бусад 2 цооногоор өндөр температурын серицитийн шаврын хувиралтай холбоотой дундаас хүчтэй цэнэгжих чадвар, хүчтэй соронзон шинж чанартай давхцаж буйг шалгахгаар өрөмдсөн. Пиритийн хүдэржилт цооногийн турш ажиглагдсан ба хамгийн өндөр бөөгнөрөлтэй хэсэг нь өндөр цэнэгжих чадвартай давхцаж байсан. Хамгийн зүүн талын цооног болох UDH-02 нь хамгийн эерэг үр дүнг үзүүлсэн бөгөөд UDH-01 болон

UDH-03 цооногуудад тогтоогдсон фон утгуудтай харьцуулбал хэсэгчлэн тохиолдох зэсийн ахиу агуулга (60 метрийн 100-300ppm Cu)-тай холбоотой зэрэгцээгээс штокверк кварц-пиритийн судалжилт илэрсэн. Мөн UDH-02 цооногийн гүнд пропилит хувирлаас филлик хувирал руу шилжиж буй бүсчлэл тодорхой ажиглагдсан. Филлик хувирал нь судал болон сарнисан хэлбэрээр тохиолдох пиритийн хүдэржилт болон соронзон шинж чанарын эрчимжилттэй давхцаж байсан. Шаврын эрдсийн спектрийн судалгаа, нас тогтоох судалгаа зэрэг ажлуудыг одоо хийж байгаа. Бүх үр дүнг нэгтгэн хянах ажлыг дараагийн шатны хайгуулын ажил эхлэхээс урьтаж хийж гүйцэтгэнэ.

Зуун Мод молибденийн төсөл

Зуун Мод молибденийн төсөл нь молибден-зэс порфирын орд бөгөөд Монголын баруун өмнөд хэсэгт оршино. Улаанбаатар хотоос баруун урд зүгт ойролцоогоор 950 км, Монгол-Хятадын хил дээрх Цэхийн галт тэрэгний боомтоос 215 км зайд байрладаг. Энэ өртөө нь Нарийн Сухайт болон Овоот Толгойн нүүрсний уурхайгаас урд зүгт 50 км-т байрладаг. Төсөл нь нийт 6,041 га талбай бүхий ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд оршдог. Энэ ашиглалтын тусгай зөвшөөрөл нь Компанийн охин компани болох Аниан Ресорсиз ХХК-ийн эзэмшилд байдаг ба ашиглалтын тусгай зөвшөөрөл нь эхний 30 жилийн хугацаанд явж байна. Энэ төслийг Галлант Минералз Лимитэд компаниас 2005 онд авсан бөгөөд Галлант Минералз компанид буцаан худалдаж авах нөхцөлтэйгөөр 1.5%-ийн нөөцийн төлбөр төлөх үүрэг хүлээсэн.

Компани нь 2011 оны 2-р улиралд NI 43-101 стандартын дагуу Зуун Модын нөөцийг тооцоолон олон нийтэд ил болгосон. Захын агуулгыг 0.04% молибден гэж тооцон, дунджаар 0.057% молибден болон 0.069% зэсийн агуулгатай 218 сая тоннын ("Мтн") тогтоогдсон болон бодит нөөцтэй гэж тооцоолсон. Энэ нь 273.5 сая фунт металл молибден агуулсан болон 330.7 сая фунт металл зэстэй тэнцэнэ. Үүнээс гадна Зуун Модод дунджаар 0.052% молибден болон 0.065% зэсийн агуулгатай 168 сая тн таамаг нөөц байгаа ба энэ нь 191.8 сая фунт металл молибден агуулсан болон 240.5 сая фунт металл зэс агуулсан байдалтай байна.

Молибденийн энэхүү төсөл нь молибденийн үнэ өсөх үед хөгжүүлэлт хийх бүрэн боломжтой төсөл гэж үзэж байна. 2017 онд фунт тутам нь \$7.25 болон огцом унаж байсан молибденийн үнэ одоогоор өсч \$12.00 болсон. Молибденийн зах зээлийн үнийн өсөлт нь Зуун Мод молибден-зэсийн ордыг хөгжүүлэх чухал хүчин зүйл болох бөгөөд технологи болон/эсвэл хайгуултай холбоотой нэмэлт мэдээлэл гармагц төслийн эдийн засгийн оновчлолын үнэлгээг үргэлжлүүлэн хийнэ. Хөвийн Хар төсөлд зэсийн тодорхой хэмжээний нэмэлт хүдэржилт илрүүлснээр Зуун Мод молибденийн ордыг хөдөлгөх хөшүүрэг болох боломжтой.

Зуун Мод ордын нөөцийн тайланг SEDAR-т байршуулсан бөгөөд "Technical Report Zuun Mod Porphyry Molybdenum-Copper Project, South-Western Mongolia, National Instrument 43-101 Independent Technical Report" нэртэйгээр 2011 оны 6-р сард бүртгүүлсэн.

Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл

Хөвийн Хар зэс-мөнгөний төсөл нь Зуун Мод ордын ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байх ба Зуун Мод молибден-зэсийн порфирийн ордоос баруун хойд зүгт 2.2 км зайд байрладаг. Хөвийн Хард геологийн зураглал, судлын нягтаршлын зураглал, геохимийн дээжлэлт, геофизикийн судалгаа болон хол алслалтай өрөмдлөгийн ажлуудыг хийсэн. Өмнө нь хийсэн геофизикийн гажилтай цэг шалгах өрөмдлөгийн судалгаагаар 308-342 метр гүнд 1.3% зэс болон 9.24 г/т мөнгөний агуулгатай 34 метрийн интервал огтолсон. Хөвийн Хард хийсэн нэмэлт өрөмдлөгийн ажлаар том хэмжээний буюу 900 метр үргэлжлэх, зэсийн хэд хэдэн эрдэсжсэн бүс байгааг илрүүлсэн. Өрөмдсөн гурван цооногт 0.2%-аас илүү зэсийн агуулгатай тодорхой интервалууд (12-42 метр) огтлогдсон.

Худалдан авалт

2018 оны 3-р улиралд Монгол улсын Уул Уурхай, Хүнд Үйлдвэрийн Яамнаас тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож эхэлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, хэтийн төлөвтэй талбайнуудыг тодорхойлсон. Энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна. Түүнээс гадна хувийн өмчийн хуулийн этгээдүүдтэй хэлцэл хийх замаар тусгай зөвшөөрлийн талбайг эзэмших боломжуудыг судалж байна. Эрдэнэ-Текийн гэрээний дагуу Тек Ресурс Лимитед компанитай Монгол улсын баруун-өмнөд хэсэгт идэвхтэй хамтран ажилласаар байна.

Үйл ажиллагааны хэлэлцүүлэг

2018, 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын мэдээлэл

Доорх хүснэгтэд 2018, 2019 оны 6 сарын 30-ны байдлаар хайгуул болон үнэлгээний зардлыг харуулав. Энэхүү хугацаанд Хөндий Алтны Төсөл ба Улаан тусгай зөвшөөрлийн талбайд төвлөрч ажилласан.

2019.06.30 байдлаар	Хөндий Алтны			Нийт
	Төсөл	Зуун Мод	Улаан ба бусад	
Хайгуулын зардал				
Уурхайн судалгаа, зөвшөөрлүүд	\$ 913,207	\$ -	\$ -	\$ 913,207
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж шинжилгээ	293,224	717	426	294,367
Хайгуул, кемп, хээрийн ажлууд	197,251	10,354	68,341	275,946
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	89,401	89,401
Тусгай зөвшөөрөл	16,488	67,091	612	84,191
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	77,278	77,278
Оролцогч талуудтай харилцах	61,540	-	-	61,540
Томиллолт болон бусад	12,011	-	(481)	11,530
Нийт хайгуулын зардал	1,493,721	78,162	235,577	1,807,460
Капиталжуулсан зардал	(1,493,721)	(67,091)	(612)	(1,561,424)
2019 онд зарлагдсан хайгуулын зардлууд	\$ -	\$ 11,071	\$ 234,965	\$ 246,036
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2019.04.01	\$ 14,527,417	\$ 818,492	\$ 916,989	\$ 16,262,898
Нэмэлт	1,493,721	67,091	612	1,561,424
БЦАТ буцаан худалдан авалт	1,200,000	-	-	1,200,000
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(339,425)	(26,033)	(16,568)	(382,026)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2019.06.30	\$ 16,881,713	\$ 859,550	\$ 901,033	\$ 18,642,296

2018.06.30	Хөндий Алтны			Нийт
	Төсөл	Зуун Мод	Улаан ба бусад	
Хайгуулын зардал				
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж шинжилгээ	\$ 917,251	\$ 715	\$ 43,894	\$ 961,860
Хайгуул, кемп, хээрийн ажлууд	554,764	20,132	205,403	780,299
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	345,844	345,844
Оролцогч талуудтай харилцах	102,270	-	-	102,270
Тусгай зөвшөөрөл	5,223	70,074	2,051	77,348
Томиллолт болон бусад	66,739	-	9,568	76,307
Уурхайн судалгаа, зөвшөөрлүүд	72,176	-	-	72,176
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	46,071	46,071
Нийт хайгуулын зардал	1,718,423	90,921	652,831	2,462,175
Капиталжуулсан зардал	(1,718,423)	(70,074)	(663)	(1,789,160)
2018 онд зарлагдсан хайгуулын зардлууд	\$ -	\$ 20,847	\$ 652,168	\$ 673,015
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2018.04.01	\$ 10,506,264	\$ 796,575	\$ 958,384	\$ 12,261,223
Нэмэлт	1,718,423	70,074	663	1,789,160
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(64,826)	(5,914)	(9,209)	(79,949)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2018.06.30	\$ 12,159,861	\$ 860,735	\$ 949,838	\$ 13,970,434

2018 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$2,462,175 байсан хайгуулын зардал нь 2019 оны мөн үед \$1,807,460 болж буурсан. 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд уурхайн судалгаа, тусгай зөвшөөрлийн зардлууд \$913,207 байсан нь 2018 оны мөн үеийн \$72,176 доллартай харьцуулахад өссөн үзүүлэлт юм. Энэ нь 2019 оны 3 сард урьдчилсан ТЭЗҮ-г боловсруулж эхэлсэнтэй холбоотой.

Өрөмдлөг, сувгийн малталт дээж шинжилгээ нь нь 2019 оны 2-р улиралд \$294,367 байсан нь 2018 оны мөн үеийн \$961,860 доллартай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь 2018 онд Баян Хөндийн анхан шатны нөөцийн тооцооллыг гаргахад зориулан 4,584 метрийн өрөмдлөгийн хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан бол 2019 онд урьдчилсан ТЭЗҮ-тэй холбоотойгоор 1,800 метрийн өрөмдлөг хийсэнтэй холбоотой. Хайгуул, кемп, хээрийн ажлуудын зардал нь 2019 онд \$275,926 байсан нь өнгөрсөн үеийн мөн үеийн \$780,299-тэй харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэ нь мөн

өрөмдлөгийн ажлууд буурсантай холбоотой. Томилолтын зардлууд өрөмдлөгтэй холбоотойгоор \$11,530 болж буурсан.

2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хугацаанд хувьцаанд суурилсан бэлэн бус нөхөн төлбөр \$89,401 байсан нь 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хугацааны \$345,844-тай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Энэхүү бууралт нь хувьцааны ханш суларснаар хувьцааны опционы бодит үнэ цэн буурсантай холбоотой.

Монгол дахь оффисийн зардал 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$77,278 байсан нь өнгөрсөн оны мөн үеээс \$31,207 доллараар өссөн үзүүлэлт юм. Энэ нь Эрдэнэ Ресурс Монголын Хөрөнгийн Биржид давхар бүртгүүлсэн зохицуулалтын зардлуудыг капиталжуулсантай холбоотой.

Оролцогч талуудтай харилцахад зарцуулсан зардал нь 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд of \$28,210 буюу өнгөрсөн оны мөн үеэс \$43,674 буурсан үзүүлэлттэй байгаа нь 2019 онд орон нутгийн зөвлөх үйлчилгээ, маркетинг сурталчилгаа буурсанаас үүдсэн.

2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон хугацаанд тусгай зөвшөөрлийн зардлууд нь өнгөрсөн оны мөн үеэс өөрчлөгдөөгүй.

Эрдэнэ Ресурс нь Хөндий Алтны Төслийн Алтан Нар ордын анхан шатны нөөцийн тайланг хүлээн авснаар 2015 оны 1 сарын 1-нээс хойш Хөндий Алтны Төслийн хайгуулын зардлыг капиталжуулж эхэлсэн. 2018, 2019 оны 6 сарын 30-аар дуусгавар болсон гурван сарын хугацаанд Компани нь дээрх төсөлтэй холбоотой бүх хайгуулын зардлуудыг капиталжуулсан.

	6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сар		
	2019	2018	Өөрчлөлт
Захиргааны үйлчилгээ	\$ 94,207	\$ 149,359	\$ (55,152)
Элэгдэл, хорогдол	2,153	1,554	599
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр	37,091	51,107	(14,016)
Хөрөнгө оруулагчидтай харилцах, маркетинг	23,093	24,978	(1,885)
Оффис болон бусад	30,205	34,783	(4,578)
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	46,087	55,676	(9,589)
Зохицуулагч байгууллагын төлбөр	22,568	26,481	(3,913)
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	236,109	430,823	(194,714)
Томилолтын зардал	6,415	16,678	(10,263)
	\$ 497,928	\$ 791,439	\$ (293,511)

2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд захиргаа, удирдлагын зардал \$497,928 байсан нь өнгөрсөн оны мөн үеийн \$791,439 доллартай харьцуулахад буурсан үзүүлэлт юм. Захиргааны үйлчилгээ өнгөрсөн оны мөн үеэс \$55,152 доллараар буурсан буюу \$94,207 болсон нь ажилтан, албан тушаалтнуудын гүйцэтгэлийн урамшууллын хугацаа 2018 оны 6 сард төлөгдсөнөөс 2019 онд 7 сард төлөгдөж өөрчлөгдсөнтэй холбоотой. ТУЗ-ийн гишүүдийн төлбөр нь 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд \$37,091 буюу өнгөрсөн оны мөн үеэс \$14,016 буурсан нь тодорхой ТУЗ-ийн гишүүд урамшууллыг бэлэн бус хувьцаанд суурилсан нөхөн төлбөрөөр хүлээн авахыг зөвшөөрснөөс үүдсэн. Бэлэн бус хувьцаанд суурилсан нөхөн төлбөр нь өнгөрсөн оны мөн үеэс \$194,714 буурсан нь дээр дурдсан ТУЗ-ийн гишүүдийн урамшууллын хөтөлбөрт орсон өөрчлөлт болон Black-Scholes моделийн дагуу опционы үнийг тооцоолоход бодит үнэ цэн буурсантай холбоотой.

Элэгдэл, хорогдол, хөрөнгө оруулагчидтай харилцах маркетинг, оффис болон бусад, мэргэжлийн үйлчилгээний төлбөр, зохицуулагч байгууллагын төлбөр болон томилолтын зардал нь энэхүү тайланд тусгахаар материаллаг өөрчлөлт ороогүй.

2018, 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сарын хугацаанд

2018, 2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон 6 сарын хугацаанд хайгуул, үнэлгээ болон захиргааны зардлын мэдээллийг доор хүснэгтэд харуулав.

2019.06.30 дуусгавар болсон	Хөндий Алтны			Нийт
	Төсөл	Зуун Мод	Улаан ба бусад	
Хайгуулын зардал				
Уурхайн судалгаа, зөвшөөрлүүд	\$ 1,406,978	\$ -	\$ -	\$ 1,406,978
Хайгуул, кемп, хээрийн ажлууд	414,374	20,603	155,101	590,078
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж шинжилгээ	296,272	1,184	968	298,424
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	150,548	150,548
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	93,777	93,777
Оролцогч талуудтай харилцах	89,750	-	-	89,750
Тусгай зөвшөөрөл	16,995	67,091	1,902	85,988
Томилолт ба бусад	31,595	-	1,405	33,000
Нийт хайгуулын зардал	2,255,964	88,878	403,701	2,748,543
Капиталжуулсан зардал	(2,255,964)	(67,091)	(1,902)	(2,324,957)
2019 онд зарлагадсан хайгуулын зардлууд	\$ -	\$ 21,787	\$ 401,799	\$ 423,586

Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2019.01.01	\$ 13,930,310	\$ 831,726	\$ 925,312	\$ 15,687,348
Нэмэлт	2,255,964	67,091	1,902	2,324,957
БЦАТ буцаан худалдан авсан төлбөр	1,200,000	-	-	1,200,000
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	(503,797)	(39,267)	(26,945)	(570,009)
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2019.06.30	\$ 16,882,477	\$ 859,550	\$ 900,269	\$ 18,642,296

2018.06.30	Хөндий Алтны			Нийт
	Төсөл	Зуун Мод	Улаан ба бусад	
Хайгуулын зардал				
Хайгуул, кемп, хээрийн ажлууд	\$ 912,290	\$ 29,568	\$ 301,199	\$ 1,243,057
Өрөмдлөг, сувгийн малталт, дээж шинжилгээ	918,397	1,380	50,825	970,602
Хувьцаанд суурилсан нөхөн төлбөр	-	-	355,037	355,037
Монгол дахь оффисийн зардлууд	-	-	143,386	143,386
Оролцогч талуудтай харилцах	139,948	-	-	139,948
Томилолт ба бусад	109,374	-	18,207	127,581
Уурхайн судалгаа, зөвшөөрлүүд	123,122	-	-	123,122
Тусгай зөвшөөрөл	5,223	70,074	2,051	77,348
Нийт хайгуулын зардал	2,208,354	101,022	870,705	3,180,081
Капиталжуулсан зардал	(2,208,354)	(70,074)	(2,051)	(2,280,479)
2018 оны зардлагадсан хайгуулын зардлууд	\$ -	\$ 30,948	\$ 868,654	\$ 899,602

Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2018.01.01	\$ 9,700,832	\$ 765,795	\$ 928,216	\$ 11,394,843
Нэмэлт	2,208,354	70,074	2,051	2,280,479
Валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө	250,675	24,866	19,571	295,112
Хайгуул, үнэлгээний хөрөнгө 2018.06.30	\$ 12,159,861	\$ 860,735	\$ 949,838	\$ 13,970,434

	6.30-нд дуусгавар болсон зургаан сар		
	2019	2018	Өөрчлөлт
Захиргааны үйлчилгээ	\$ 204,123	\$ 270,652	\$ (66,529)
Элэгдэл, хорогдол	4,065	3,053	1,012
ТУЗ-ийн гишүүдийн төлбөр	65,009	75,142	(10,133)
Хөрөнгө оруулагчидтай харилцах, м:	55,316	90,149	(34,833)
Оффис болон бусад	62,123	64,166	(2,043)
Мэргэжлийн үйлчилгээний төлбөр	77,886	117,978	(40,092)
Зохицуулагч байгууллагын төлбөр	70,805	86,803	(15,998)
Хувьцаанд суурилсан нөхөн олговор	284,183	536,977	(252,794)
Томилолтын зардал	20,734	33,127	(12,393)
	\$ 844,244	\$ 1,278,047	\$ (433,803)

Улирлын үр дүнгийн хураангуй

Хувьцааны тоо хэмжээнээс бусад дүнг мянган Канад доллараар илэрхийлэв.

	Санхүүгийн	Санхүүгийн жил 2018				Санхүүгийн жил 2017		
	жил 2019							
	Q2	Q1	Q4	Q3	Q2	Q1	Q4	Q3
	6 сар	3 сар	12 сар	9 сар	6 сар	3 сар	12 сар	9 сар
Алдагдал	\$755	\$517	\$772	\$744	\$1,439	\$702	\$649	\$713
Нэгж хувьцаанд ногдох алдагдал	\$0.01	\$0.00	\$0.01	\$0.00	\$0.01	\$0.00	\$0.00	\$0.01
Нийт хөрөнгө	\$19,365	\$19,632	\$17,709	\$18,136	\$19,500	\$14,879	\$14,946	\$15,592

2019 оны 6 сарын 30-нд дуусгавар болсон гурван сарын хугацаанд Компани нь \$755,291 долларын цэвэр алдагдалтай ажилласан нь 2018 оны мөн үеийн \$1,271,978 доллартай харьцуулахад буурсан үзүүлэлт юм.

Компанийн зардал нь Монгол дахь хайгуулын хөтөлбөрүүдээс хамаарч улирал тутамд харилцан адилгүй байдаг. Компани нь өнгөрсөн хугацаанд санхүүгийн үр дүнд нөлөөлж болохуйц мэдээ болон тодорхой чиг хандлагын тухай мэдээлэл аваагүй болно.

Төлбөр гүйцэтгэх чадвар болон капитал нөөц

Энэхүү УХДШ гарах өдрөөр Компанийн эргэлтийн хөрөнгийн хэмжээ ойролцоогоор \$1.4 сая канад доллар байна.

Татан төвлөрүүлсэн хөрөнгийг Компанийн Монгол улсад хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, тэдгээрийг дэмжих захиргааны зардлуудыг санхүүжүүлэхэд зарцуулсан (Хайгуул, хөгжүүлэлтийн төслүүд ба Үйл ажиллагааны хэлэлцүүлгээс танилцана уу).

2019 оны 7 сарын 9-нд Компани нь хаалттай хүрээнд нийт \$2,001,500 кан.долларыг татан төвлөрүүлсэн бөгөөд энэхүү хөрөнгө нь 2019 оны 9-р сар хүртэл Компанийн төлөвлөсөн зардлуудыг санхүүжүүлэх боломжтой гэж үзэж байна. Компани нь өөрийн хайгуулын хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх чадвар нь хөрөнгө борлуулах, түншлэл байгуулах, опцион болон хамтын ажиллагааны гэрээ хэлцэл байгуулах, хувьцааны санхүүжилт хийх болон/эсвэл зардал бууруулах зэргээр тодорхойлогдоно. Нэмэлт санхүүжилт хийх хугацаа, боломж, төлөвлөлт нь Компанийн хайгуулын хөтөлбөрүүдийн үр дүн болон зах зээлийн нөхцөл байдлаар тодорхойлогдоно.

Компанийн орлогын эх үүсвэр хязгаарлагдмал тул мөнгөн гүйлгээнд дүн шинжилгээ хийх эсвэл ямарваа нэг бодитой чиг хандлагыг тодорхойлоход бэрхшээлтэй. Компани нь хайгуулын болон төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүдээ нэмэлт хувьцаа гаргах замаар хувьцааны санхүүжилт хийн санхүүжүүлж байна.

Энд дурдсанаас бусдаар Компани нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, урьдчилан тооцоолж болохуйц ирээдүйн капитал хөрөнгө материаллаг байдлаар өсөх/буурах аливаа чиг хандлага, шаардлага, үүрэг, үйл явдал, тодорхой бус байдлын талаар мэдээлэл байхгүй болно. Компанийн төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, капитал хөрөнгийн өсөлт, бууралт нь Монгол улс дахь хайгуул, төсөл хөгжүүлэлтийн хөтөлбөрүүд амжилттай/ амжилтгүй хэрэгжих, мөн хангалттай хувьцааны санхүүжилт хийх чадвартай эсэхээс хамаарч тодорхойлогдоно.

Эргэлтэд буй хувьцааны мэдээлэл

Хувьцаа гаргах бүрэн эрх

Нэрлэсэн үнэгүй, хязгааргүй энгийн хувьцаа гаргах эрхтэй.

Гаргасан ба эргэлтэд буй хувьцаат капитал

	2019.08.09	2018.12.31
Гаргасан ба эргэлтэд буй энгийн хувьцааны тоо	184,728,529	162,426,416
Опцион	12,520,000	11,335,000
Варрант	27,711,744	12,389,904
ИОХЭ	4,541,440	3,954,118
Нийт гаргасан санхүүгийн хэрэгсэл	229,501,713	190,105,438

Гэрээгээр хүлээсэн үүрэг

Дараах хүснэгтэд 2019 оны 6 сарын 30-ны байдлаар Компанийн гэрээгээр хүлээсэн үүргийг харуулав:

	Нийт	>1 жил	1-3 жил	4-5 жил	5< жил
Оффисийн түрээс	\$59,311	\$59,311	\$ -	\$ -	\$ -
Дансны өглөг ба хуримтлагдсан өр төлбөр	753,436	753,436	-	-	-
	\$812,747	\$812,747	\$ -	\$ -	\$ -

Бусад санхүүгийн зохицуулалт ба үүрэг

Сэндсторм Гоулд (“Sandstorm Gold Ltd”) Роялти гэрээ

2016 оны 4 сарын 21-нд Компани нь Сэндсторм Гоулд Лтд. (“Sandstorm”) компанид Цэнхэр Номин болон Хөндий тусгай зөвшөөрлүүдэд 2%-ийн борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг (“NSR”) төлөх хэлцэл хийсэн. Сэндсторм нь Хөндий болон Цэнхэр Номингийн тусгай зөвшөөрлүүдтэй холбоотой ирээдүйн роялти санхүүжилтэд хориг тавих эрхтэй. 2019 оны 4 сарын 12-нд Эрдэнэ Ресурс нь Сэндсторм (“Sandstorm Gold Limited”) -д борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийн 50%-ийг 1.2 сая кан.доллараар худалдан авч, борлуулалтын цэвэр ашгийн төлбөрийг 1% хүртэл бууруулсан.

Тек Ресорсиз Лимитэд (“Teck Resources Limited”) компанитай байгуулсан түншлэл

2013 оны 4 сард Монгол улсын баруун өмнө хэсэгт байрлах Транс Алтай бүсэд Компанийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий талбайд хайгуулын судалгааг хамтран хийх, санхүүжилт хийх хүрээнд Тек Ресорсиз Лимитэд компанитай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу Тек нь Компанид 3 сая долларын хөрөнгө оруулалт хийх, эсвэл Компанийн зарласан хувьцааны 19.9%-ийг эзэмших нөхцөлтэй бөгөөд нийт хөрөнгө оруулалтын 85%-ийг хайгуулын судалгаанд зарцуулахаар төлөвлөсөн. Тек нь дахин санхүүжилтийн аргаар шинэ төслүүдээс 75% хүртэл эзэмших боломжтой 2 үе шаттай опцион эрхтэй.

2013 оны 2-р улирлаас 2017 оны 1-р улирлын хооронд гэрээний дагуу Тек нь 3 сая долларын хөрөнгө оруулалт хийж гэрээний нөхцөлийг биелүүлсэн. 2020 оны 1-р улирлыг дуустал Тек нь Компанийн шинээр нээн илрүүлсэн нээлтүүдэд түншлэлийн гэрээ хийх эрх нь нээлттэй.

Бусад

Галлант Минералз Лимитед (“Gallant Minerals Limited”) нь Компанийн Зуун Мод тусгай зөвшөөрлийн борлуулалтын цэвэр ашгаас 1.5%-ийн төлбөр (“БЦА”) хүртэх эрхтэй. Зуун Мод ашиглалтын тусгай зөвшөөрлийн хүрээнд хайгуулын судалгаа, ажил хийх үүрэг хүлээгээгүй.

2018 онд Компанийн Цэнхэр Номин болон Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд га тус бүрд \$1.5 ам.долларыг хайгуулын зардалд зарцуулах үүрэг хүлээсэн (тус бүр \$7,004, \$6,771 болсон).

Компани нь Лидер Эксплорэйшн ХХК-ийн 49%-ийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээгээр худалдан авах эрх үүсгэхийн тулд 2020 оны 8 сарын 30 хүртэл \$600,000 ам.долларын хайгуулын судалгааг хийх үүрэгтэй (Улаан тусгай зөвшөөрлийн талбай). Энэхүү 3 жилийн опционы хугацааг жилд \$100,000 ам.долларыг хайгуулын ажилд зарцуулснаар сунгах боломжтой. Эрдэнэ Ресурс нь хайгуулын ажлын зарцуулалтын хамгийн бага хэмжээг гүйцэтгэж чадаагүй нөхцөлд 51%-ийн өмчлөл нь Лидер Эксплорэйшн ХХК-д буцан шилжинэ.

Балансын гадуурх зохицуулалт

Компани нь 2019 оны 6 сарын 30-ны байдлаар батлан даалтын гэрээ, өөр бусад байгууллагад хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой болзошгүй үүрэг, үүсмэл хэрэгсэл буюу Компанид санхүүжилт,

хөрвөх чадвар, зах зээлийн болон зээлийн эрсдэл учруулж болзошгүй аливаа үүрэг гэх мэт балансын гадуурх аливаа зохицуулалт хийгээгүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн үндсэн тооцоолол

Санхүүгийн бус хөрөнгийн нөхөгдөх дүнгийн тооцоолол

Үйл явдал, нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан тодорхой жилд үнэ цэн бууралтын гарз гарах буюу үнэ цэн бууралтын гарзын буцаах бичилт хийх шаардлага гарч болно.

Корпорацийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу санхүүгийн бус хөрөнгө буюу бэлэн мөнгө бий болгох нэгжийг тайлант жил бүр үнэлж, үнэ цэнийн бууралтын шинж тэмдэг байгаа эсэхийг нягтална. Хэрэв ийм шинж тэмдэг байгаа бол нөхөгдөх дүнг албан ёсоор тооцоолж, нөхөгдөх дүнгээс хэтэрсэн дансны үнээр үнэ цэн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө. Хөрөнгийн буюу бэлэн мөнгө бий болгох нэгжийн нөхөгдөх дүнг хөрөнгийн борлуулалтын цэвэр үнэ ба ашиглалтын үнэ цэнийн аль ихээр бүртгэнэ. Гүүдвиллийн зорилгоор жил бүр үнэ цэн бууралтыг шалгана.

Бодит үнэ цэнийг холбоогүй талуудын ажил гүйлгээгээр зохих мэдлэгтэй, арилжаанд оролцоход бэлэн байгаа талуудын хооронд хөрөнгө солилцож болох дүн гэж тодорхойлох ба ерөнхийдөө хэтийн төлөвт талбайг тэлэх, яваандаа данснаас хасах байдлаар хөрөнгийг үргэлжлүүлэн ашигласнаас үүсэхээр хүлээгдэж байгаа тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн юм. Ашиглалтын үнэ цэн гэдэг нь хөрөнгийг өнөөгийн хэлбэрээр нь тасралтгүй ашигласнаас болон ашиглахаар тооцсон хугацааны эцэст данснаас хасах үед үүсэхээр хүлээгдэж байгаа тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэн юм. Өнөөгийн үнэ цэнийг тухайн хөрөнгөд агуулагдах эрсдэлүүдэд тохирох эрсдэлийн тохируулалттай татварын өмнөх хорогдуулагч ашиглан тодорхойлно.

Ирээдүйн мөнгөн урсгалын тооцоолол нь хүлээгдэж буй үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ (одоогийн болон түүхэн үнэ, үнийн чиг хандлага, холбогдох хүчин зүйлсийг харгалзана), нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээлтийн зардал, ирээдүйн капитал зардалд тулгуурлана. Хөрөнгийн нөхөгдөх дүнд нөлөө үзүүлж болзошгүй төсөөлөл нь нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалан өөрчлөгдөх боломжтой тул энэхүү бодлого нь эрсдэл болон тодорхой бус байдалд өртөж болзошгүй эдгээр тооцоолол, төсөөллийг хийхийг удирдлагаас шаарддаг. Энэ тохиолдолд хөрөнгийн дансны үнэ бүхэлдээ буюу хэсэгчлэн буурч болох ба үнэ цэнийн бууралтыг орлогын тайлангаас хасна.

Хувьцаанд суурилсан төлбөр

Ажилтнуудад олгосон өмчөөр хаагдах хувьцаанд суурилсан төлбөрийг олгосон өдрөөр бодит үнэ цэнээр (зах зээлд сурилаггүй баталгаажих нөхцөлийн нөлөөг тооцохгүй) бүртгэнэ. Бодит үнэ цэнийг Black-Scholes үнэлгээний загварыг ашиглан тооцох ба ингэхдээ бодит үнэ цэнийг бүртгэх үед мэдэгдэж буй мэдээлэлд тулгуурлан хүлээгдэж буй хэлбэлзэл болон хүлээгдэж буй хугацаа гэх мэт хувьсагчуудын хүрээнд шийдвэр гаргаж үнэлэхийг шаарддаг. Компани 2019 оны 6 сарын 30-ны өдрөөр дуусгавар болсон 6 сарын хугацааны бэлэн бус, хувьцаанд суурилсан нөхөн төлбөрт нийт \$377,960 долларыг зарцуулсан. (2018 - \$892,014)

Татвар

Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын татвартай холбогдох хэсэгт удирдлагын зүгээс тайлан балансад хойшлогдсон татварын хөрөнгө, хойшлогдсон татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлж, шийдвэр гаргана. Ирээдүйд татвар ногдох хангалттай ашиг төвлөрүүлэх эсэхээс хамаарч нөхөгдөх боломжтой тохиолдолд л татварын алдагдлыг ирээдүйд шилжүүлснээс, капиталын алдагдал болон түр зөрүүгээс үүсэх хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйд татвар ногдох хангалттай ашиг төвлөрүүлэх тухай төсөөлөл нь ирээдүйн мөнгөн урсгалын талаарх удирдлагын тооцооллоос хамаарна. Энэ бүхэн нь ирээдүйн үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, ашигт малтмалын үнэ, нөөц, үйл ажиллагааны зардал, нөхөн сэргээх зардал, капитал зардал, ногдол ашиг болон капиталын менежментийн бусад хэлцэл, гүйлгээнээс шалтгаална.

Түүнчлэн орлогын албан татварын хууль тогтоомжийн асуудлаар шийдвэр гаргах шаардлагатай. Нөхцөл байдлын өөрчлөлт нь тайлан балансад хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгийн болон хойшлогдсон татварын өрийн дүн, харахан хүлээн зөвшөөрөгдөөгүй байгаа татварын бусад алдагдал болон түр зөрүүгийн дүнд нөлөөлж, хүлээгдэж буй үр дүнг өөрчлөх боломжтой тул эдгээр шийдвэр болон төсөөлөл нь эрсдэл болон тодорхой бус байдалд өртөх магадлалтай байдаг. Энэ тохиолдолд хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон татварын хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэд бүхэлд нь эсвэл хэсэгчлэн тохируулалт хийхэд орлогын тайланд харгалзах хөнгөлөлт, төлбөр үүснэ.

Компанийн нягтлан бодох бүртгэлийн голлох тооцоололд сүүлийн 2 жилийн хугацаанд өөрчлөлт ороогүй болно.

Нягтлан бодох бүртгэлийн шинээр батлагдсан стандарт

Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын хүрээнд Компани нь 2019 оны 1 сарын 1-нээс дараах шинэ стандарт, нэмэлт өөрчлөлт, тайлбарыг даган мөрдөж эхлээд байна.

СТОУС 16 - Түрээс

ОУСЗ 2016 оны 1 сарын 13-нд СТОУС 16-Түрээсийг гаргасан. Уг стандарт нь нягтлан бодох бүртгэлийн нэг түрээслэгчийн загварыг танилцуулсан ба үндсэн хөрөнгө нь бага өртөгтэй биш бол 12 сараас дээш хугацаатай бүх түрээсийн хөрөнгө, өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх шаардлагыг түрээслэгчид тавьдаг. НББОУС 17-той адил, энэхүү стандартын дагуу түрээслүүлэгч нь түрээсийн зардлыг үйл ажиллагаа эсвэл санхүүгийн бүрэлдэхүүнээр ангилна. СТОУС 16 нь 2019 оны 1 сарын 1-ээс эхлэн буцан үйлчлэх нөхцөлтэйгөөр мөрдөж эхлэнэ.

Компани нь 2019 оны 1 сарын 1-ээс СТОУС 16 Түрээсийн стандартыг буцан үйлчлэх нөхцөлтэйгөөр мөрдөж эхэлсэн. 2018 оны мэдээлэл нь энэхүү тайланд тусгагдаагүй бөгөөд урьд нь НББОУС 17-д болон холбогдох тайлбаруудад тусгагдсан.

Компани нь 12 сараас доош хугацааны түрээсийн гэрээ хэлцэл байхгүй тул энэ нь Компанийн үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэхгүй.

Санхүүгийн хэрэгсэл ба бусад эрсдэл

Санхүүгийн хэрэгслүүд

Компанийн санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэн нь дансны үнэтэйгээ ойролцоо гэж үзэв. Бодит үнэ цэн гэдэг нь зах зээлд оролцогч талуудын хооронд хөрөнгө борлуулсны дүнд хүлээн авах үнэ эсвэл дэс дараатай хэлцэл гүйлгээгээр өр төлбөрийг шилжүүлэхээр харилцан тохиролцож, хэлцлийн өдрөөр үнэлэгдэх үнэ юм. Бодит үнэ цэнийн эрэмбэ нь бодит үнэ цэнийг хэмжих үнэлгээний аргад өгөгдлийг ангилах түвшнүүдийг тогтоодог.

Түвшин1: Идэвхтэй зах зээлд нэг төрлийн хөрөнгө эсвэл өр төлбөрийн өгөгдөл нь тогтоосон үнэтэй байна.

Түвшин 2: Өгөгдөл нь идэвхтэй бус зах зээлийн тогтоосон үнэ, идэвхтэй зах зээл дэх ижил төстэй хөрөнгө буюу өр төлбөрийн тогтоосон үнэ, хөрөнгө эсвэл өр төлбөрийн хувьд хэмжиж болохуйц тогтоосон үнээс бусад өгөгдөл, эсвэл хэмжиж болохуйц зах зээлийн дүн мэдээгээр болон бусад хэрэгслээр нотлогдсон буюу эдгээрээс голчлон бий болсон өгөгдөл байна.

Түвшин 3: Өгөгдөл нь хэмжиж болохуйц бус (зах зээлийн үйл ажиллагаа бага, эсвэл огт дэмждэггүй) байна.

Бодит үнэ цэн

2018 оны 12 сарын 31-нээс 2019 оны 6 сарын 30 хүртэл хугацаанд Түвшин 1, Түвшин 2, Түвшин 3-ын хооронд ангилагдсан хөрөнгө, өр төлбөрийн хэлцэл гүйлгээ байхгүй байна. Дараах хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэн болон эрэмбэд эзлэх түвшнийг харуулав.

	2019.06.30			2018.12.31		
	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3	Түвшин 1	Түвшин 2	Түвшин 3
Санхүүгийн хөрөнгө:						
Мөнгө болон түүнтэй адилтгах	\$ 353,842	\$ -	\$ -	\$ 1,748,249	\$ -	\$ -
Авлага	-	157,343	-	-	113,412	-

Эрсдэлүүд

Компани нь үйл ажиллагаа явуулах хугацаандаа голчлон хайгуулын үр дүн, металл болон түүхий эдийн үнэтэй холбоотой эрсдэл, тодорхой бус байдалтай тулгардаг. Ашигт малтмалын хайгуул, уул уурхайн үйл ажиллагааны хөгжүүлэлт нь олон эрсдэл дагуулдаг бөгөөд дийлэнх нь Компанийн хяналтаас давсан байдаг. Компани нь дэд бүтэц сул хөгжсөн алслагдмал байршилд үйл ажиллагаа явуулдаг гадна хайгуул, ашиглалтын хэвийн болон ердийн эрсдэлүүдтэй тулгарч байдаг. Эдгээр эрсдэлүүдийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэлтэй SEDAR www.sedar.com-д байрлах Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс танилцах боломжтой.

Зээлийн эрсдэл

Компани нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын “Schedule I” (Канад улсын дотоодын банкууд) банкинд хадгалуулдаг бөгөөд ингэснээр бэлэн мөнгөний эрсдэлийг бууруулах боломжтой гэж Компанийн удирдлага үздэг. 2019 оны 6 сарын 30-ны байдлаар нийт мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 39% буюу \$136,519 долларыг Канадаас өөр улсад хадгалуулж байна. (2018.12.31- \$66,342, 4%)

Хөрвөх чадварын эрсдэл

Компанийн хөрвөх чадварын эрсдэл нь өр төлбөрөө хугацаанд нь төлж барагдуулах үүргээ биелүүлэхэд үүсэж болзошгүй хүндрэлтэй холбоотой эрсдэлийг хэлнэ. Компани нь энэхүү эрсдэлийн удирдлагын хүрээнд санхүүгийн хэвийн болон хүндрэлтэй аль ч нөхцөлд шаардлагагүй гарз хүлээхгүйн тулд санхүүгийн өр төлбөр төлөгдөх хугацаанд хангалттай хэмжээний нөөцтэй байх бодлого баримталдаг. 2019 оны 6 сарын 30-ны байдлаар Компанийн бэлэн мөнгөний үлдэгдэл \$353,842 (2018.12.31 - \$1,748,249)-аар \$753,436 долларын богино хугацаат өр төлбөрийг (2018.12.31 - \$224,387) барагдуулна.

Компани нь хайгуулын шатандаа яваа бөгөөд үүнд хайгуулын шатанд яваа харьцуулж болох бусад компаниудын нэгэн адил эрсдэл, сорил бэрхшээл тулгарч болно. Эдгээр эрсдэлүүдэд гол ажилтнуудаас хамааралтай байх, хайгуулын үр дүн, төслүүдийг амжилттай хөгжүүлэх, тасралтгүй ажиллах зарчмыг хангахад шаардагдах хамгийн бага капитал нөөцийг баталгаажуулах чадвар зэрэг багтах боловч зөвхөн эдгээрээр үл хязгаарлагдана.

Гадаад валютын эрсдэл

Эрдэнэ Ресурс нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг тул гадаад валютын хөрвүүлгийн ханшийн эрсдэлтэй. Уг эрсдэлийг бууруулах зорилгоор Компани нь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийг Канадын өндөр зэрэглэлийн санхүүгийн байгууллагад байршуулдаг. Компани нь гадаад валютын ханшийн хэлбэлзлийн эрсдэлээс хамгаалан хязгаар тогтоох санхүүгийн хэлцлүүдийг ашигладаггүй бөгөөд төсвийн хэмжээнд нийцүүлэн ханш боломжийн байх үед гадаад валютыг урьдчилан худалдаж авдаг.

Компанийн ам.долларын ханшийн эрсдэлд өртөх магадлалтай хөрөнгө 2019 оны 6 сарын 30-ны байдлаар \$136,156 (2018.12.31 - \$71,913) байна. Ам.долларын ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$13,100 (2018.12.31 - \$7,200) долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай.

Компанийн монгол төгрөгийн ханшийн эрсдэлд өртөх магадлалтай хөрөнгө 2019 оны 6 сарын 30-ны байдлаар \$164,344 (2018.12.31 - (\$11,509)) байна. Төгрөгийн ханшид орох 10%-ийн өөрчлөлт нь \$16,400 (2018.12.31 - \$1,200) долларын цэвэр алдагдал дагуулах магадлалтай.

Үнийн эрсдэл

Компани нь тодорхой ашиггүй тул түүхий эдтэй холбоотойгоос бусад санхүүгийн хэрэгсэл, хайгуул, олборлолтын салбар дахь компаниудад нөлөөлдөг үнийн хэлбэлзэл, үнийн шууд эрсдэлд өртөхгүй.

Санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт ба дотоод хяналт

Эрдэнэ Ресурс нь Канад улсын үнэт цаасны зохицуулалтын 52-109 стандартаар батлагдсан журмын дагуу санхүүгийн тайлагналын толилуулгын хяналт, дотоод аудитыг хэрэгжүүлж байна. Гүйцэтгэх захирал (ГЗ), Санхүү хариуцсан захирал (СХЗ) нар Эрдэнэ Ресурсийн 2019 оны 6 сарын 30-ны байдлаарх толилуулгын хяналт, процедурын зохион байгуулалт, үр нөлөөг үнэлж үзээд эдгээр процедур нь Эрдэнэ Ресурс, түүний охин компаниудтай холбоотой материаллаг мэдээллийг бусдадаа үнэн зөв, бүрэн бүтэн толилуулах, жилийн тайлагналыг үндэслэлтэй гаргах боломжийг бүрдүүлсэн, үр нөлөө бүхий байна хэмээн дүгнэсэн.

ГЗ, СХЗ-ыг багтаасан Эрдэнэ Ресурсийн удирдах баг (хамтад нь “Удирдах баг” гэх) нь санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлнэ. Санхүүгийн тайлагналд тавих Эрдэнэ Ресурсийн дотоод хяналт (аудит) нь санхүүгийн тайлагналын найдвартай байдлыг хангаж, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд анхаарна.

Удирдлага нь 2019 оны 6 сарын 30-ны байдлаар Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналтын хэрэгжилт, үр нөлөөг үнэлсэн. Ийнхүү үнэлэхдээ Удирдлага нь Ивээн тэтгэгч байгууллагуудын хороо (“Committee of Sponsoring Organizations of the Treadway Commission”)–ны “Дотоод хяналт - нэгдсэн зохицуулалтын орчин (2013)” гэх тайланд тогтоосон шалгууруудыг ашигласан. Үнэлгээгээр гол эрсдэлтэй салбаруудын хяналтыг шалгаж, эдгээр хяналтуудын хэрэгжилтийг үнэлж, үр нөлөөг нь тодорхойлох зорилгоор тэдгээр хяналтуудыг туршиж, үр дүнг нь хянаж, улмаар нэгдсэн дүгнэлт гаргасан.

Удирдлагын үнэлгээнд үндэслэн ГЗ болон СХЗ нар 2019 оны 6 сарын 30-ны өдрөөр Эрдэнэ Ресурсийн санхүүгийн тайлагналд тавих дотоод хяналт нь санхүүгийн тайлагналын үнэн зөв, найдвартай байдлыг хангах, санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэхэд үр нөлөөтэй байна гэж дүгнэсэн.

Хэдийгээр дээрх систем нь үр дүнтэй хэмээн тодорхойлогддог боловч энэ нь зөвхөн санхүүгийн тайлангийн боловсруулалт болон бэлтгэлийн хувьд хамаарна. Мөн тооцооллуудын төсөөлөл нь ямар нэгэн нөхцөл байдал, зөвшөөрөл, бодлого дүрэм журмуудын өөрчлөлтөөс шалтгаалан ирээдүйд удирдах боломжгүй эрсдэл дагуулах боломжтой.

Мэргэшсэн этгээд

Петер Далтон, P. Geo, (Нова Скотиа) нь NI 43-101 стандартын дагуу шаардлага хангасан мэргэшсэн этгээд бөгөөд Компанийн хайгуулын бүх хөтөлбөрийг удирдан чиглүүлнэ. Дээжийг Монгол Улсын Улаанбаатар хот эсвэл БНХАУ-ын Тяньжинд байрлах Эс Жи Эс лаборатори ("SGS Laboratories"), Улаанбаатар хот дахь Геологийн төв лаборатори, Канадын Бритиш Колумбийн муж дахь Блю Коуст Рисерч Лтд ("Blue Coast Research Ltd") эсвэл Канадын Ванкувер хотод төвтэй ALS Chemex лабораторид тус тус шинжлүүлдэг. Эс Жи Эс лаборатори, Геологийн төв лаборатори, ALS Chemex лабораторийн дотоод хяналтаас гадна Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн эрдэсжилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн.

Энэхүү УХДШ-д толилуулсан Компанийн эзэмшиж буй ашигт малтмалын төслүүдийн шинжлэх ухааны болон техникийн мэдээллийг Компанийн хараат мэргэшсэн геосудлаач Петер Далтон хянан баталсан болно.

Бусад мэдээлэл

Компанийн талаарх нэмэлт мэдээллийг SEDAR www.sedar.com хаяг болон www.erdene.com хаяг дахь Компанийн жилийн эцсийн мэдээллийн эмхэтгэлээс үзэх боломжтой.

Орчуулга: Энэхүү тайлан нь Англи хэл дээр бэлтгэгдсэн албан тайлангийн орчуулга болно. Англи, Монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал Англи хэл дээрх хувийг мөрдөнө.